

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-51
1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	5-6
2.Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан /үргэлжилнэ/.	7-44
3.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	44-51

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
11 дүгээр сарын 11-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 28 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Саранчулуун;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Л.Гантөмөр, Т.Доржханд,
Ц.Идэрбат, Н.Номтойбаяр, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баярмаа, Л.Мөнхбаатар, Г.Уянгахишиг;
Тасалсан: Э.Болормаа, Л.Оюун-Эрдэнэ.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа санал хураалтыг гар өргөж явуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.ын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 05 цаг 17 минутаас хуралдааныг даргала

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5

Бүгд: 17

70.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван

жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан /үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга Н.Монсор, мөн зөвлөлийн гишүүн Ж.Цэсэн, Н.Онон, С.Алтанцэцэг, Д.Оюун-Эрдэнэ, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн захирал Г.Гэрэл, мөн телевизийн Тамгын дарга Г.Батзаяа, Хяналтын зөвлөлийн гишүүн Х.Энхбаяр, Б.Баясгалан, Монголын Үндэсний телевизийн захирал М.Эрдэнэбат, Монголын Үндэсний радиогийн захирал Ц.Бямбажаргал, Программ бодлого зохицуулалтын газрын дарга Н.Байгал, Техник технологи хөгжүүлэлтийн газрын дарга С.Сүхбаатар, Санхүү бүртгэл хөрөнгө оруулалтын газрын дарга А.Цэвэлсүрэн, Санхүү бүртгэлийн албаны ерөнхий нягтлан бодлогч Г.Эрдэнэцэцэг, Монголын мэдээ сувгийн Ерөнхий продюсер Д.Баяржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Тайланг Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга Н.Монсор, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн захирал Г.Гэрэл нар танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, А.Ганбаатар, С.Зулпхар, А.Ариунзаяа, Ө.Шижир, Ч.Номин, Б.Хэрлэн, О.Алтангэрэл, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга Н.Монсор, мөн зөвлөлийн гишүүн С.Алтанцэцэг, Д.Оюун-Эрдэнэ, Н.Онон, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн захирал Г.Гэрэл, Санхүү бүртгэл хөрөнгө оруулалтын газрын дарга А.Цэвэлсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, А.Ганбаатар, Д.Энхтуяа, О.Алтангэрэл, С.Зулпхар, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 12 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Уг асуудлыг 13 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 44 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 28 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд, хуралдаа ирсэн гишүүдийн нэрсийг зарлая. Дараа нь ирээгүй гишүүдийн нэрсийг зарлая.

Өнөөдөр одоо 11 сарын 11-ний өдөр. Байнгын хорооны хуралдаан өглөө 9 цагт товлогдсон. Одоо 10 цаг 25 минут болж байна. Цаг 25 минут хүлээлгэж байна.

Ирсэн гишүүд, уг нь одоо 1 гишүүн ирчихвэл ирц бүрдчих гээд байдаг. 16 гишүүн ирчхээд байна 32 гишүүнээс. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Батын Батбаатар гишүүн ирсэн байна. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн байна. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн ирсэн байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн байна. Сархадын Зулпхар гишүүн ирсэн байна. Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн ирсэн байна. Чинбатын Номин гишүүн ирсэн байна. Батчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн. Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн. Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн. Доржзовдын Энхтуяа гишүүн нарын 16 гишүүн ирээд байна. 16 гишүүн ирээгүй байна. Янз бүрийн шалтгаантай гишүүд байна. Өвчтэй, чөлөөтэй. Одоо тэгээд ирээгүй л бол ирээгүйгээр нь одоо зарлахаас өөр яах вэ. Дашзэвэгийн Амарбаясгалан гишүүн ирээгүй байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн ирээгүй байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирээгүй байна. Жудгийн Баярмаа гишүүн ирээгүй байна. Энхбатын Болормаа гишүүн ирээгүй байна. Лувсаннъямын Гантөмөр гишүүн ирээгүй байна. Тогмидын Доржханд гишүүн ирээгүй байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирээгүй байна. Лхагвын Мөнхбаатар гишүүн ирээгүй байна. Нямтайширын Номтойбаяр гишүүн ирээгүй байна. Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн ирээгүй байна. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гишүүн ирээгүй байна. Отгоны Саранчулуун гишүүн ирээгүй байна. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирээгүй байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн ирээгүй байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гэсэн 16 гишүүн ирээгүй байна одоогийн байдлаар.

Байнгын хорооны гишүүд хуралдаа товлосон цагтаа ирэх хэрэгтэй байна. Гишүүдээ, бусад гишүүдээ 1 цаг 30 минут хүлээлгэж байна. Өнөөдрийн хурлаар 3 асуудал хэлэлцэх ёстой. Ажлын алба ирээгүй гишүүд рүүгээ залгаад ирэх бололцоотой нь хэн байна гэдгээ яаралтай яриад нэр өг дөө. Цагтаа эхэлсэн бол едийд бараг хурал дуусахаар боллоо шүү дээ.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Батын Батбаатар гишүүн ирсэн. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн ирсэн. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн. Сархадын Зулпхар гишүүн ирсэн. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн ирсэн. Чинбатын Номин гишүүн ирсэн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир ирсэн. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн. Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн. Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна. Ингээд Байнгын хорооны хуралдааны ирц олонх буюу 53.1 хувийн ирцтэй болсон тул хуралдааныг эхлүүлье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоомжийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

2.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэнэ.

3.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт Хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсоно.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүн байна уу нэрсээ өгнө үү.

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орьё.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Энэ болчхож байна уу? Минийх орохгүй байна уу? Болохгүй байна тээ? Санал хураалтад бэлтгэе техникийнхэн. Санал хураалтад бэлтгэе. Болсон уу? Бэлтгэгдээгүй л байх юм. Болохгүй байна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Болохгүй байна даа энэ техникийнхэн. Техникийнхэн байгаа юм уу наад юунд чинь байгаа юу? Тэгээд яагаад болохгүй байгаа юм. Биш гэж байна шүү дээ. Энэ техникийнхэн хааччихсан юм? Тодорхой техникийн саатал гарсан юм шиг байна.

Дэгийн тухай хуулийн 10.4 ил санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл, саатал гарсан зэрэг санал хураалтын систем ажиллахгүй болсон тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулна гэсэн ийм заалт байгаа юм байна. Тэгэхээр 1 гишүүн горимын санал гаргачих. Ариунзаяа гишүүн горимын санал гаргачих

Ариунзаяа гишүүний микрофоныг өгье. Тийм байна. Бүр микрофон нь ч болохгүй байгаа юм байна. Энэ техникээс саатлаа. Ариунзаяа гишүүн одоо нэр орчихлоо шүү дээ. Ариунзаяа гишүүний микрофоныг өгье. Энэ Тамгын газрынхан энэ одоо техникийн асуудал хариуцсан энэ ажлын алба юу хийж байдаг юм бэ. Ингээд л яг хурал хуралдах болохоор л ингээд л чухал, хариуцлагатай үед л ингээд л. Тэгэхээр протоколд орохгүй биз дээ микрофонд хэлэхгүй болохоор. Микрофонд хэлж байж л. Тэгэх үү энэ дээр хэлэх үү? Тэг, эсвэл алив миний микрофон дээр ирээд Ариунзаяа гишүүн горимын саналаа гаргачхаач.

А.Ариунзаяа: Эрхэм гишүүд ээ та бүхэн маань харж байгаа байх. Манай техникийн саатал гарсан байгаа учраас бид төхөөрөмжөөр биш Дэгийн тухай хуулийн 10.4-д зааснаар гар өргөж саналуудаа хурааж явах нь зүйтэй гэж үзэж байна. Дэмжиж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн гишүүд гараа өргөнө үү. Санал хураалт явуулчихъя. Хэдэн гишүүнээс вэ?

17-гоос 16 гишүүн дэмжиж, Ариунзаяа гишүүний гаргасан горимын санал дэмжигдэж санал хураалтыг гараар илээр явуулахаар боллоо. Санал хураалт явуулъя.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газраас 2025 оны 10 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн гишүүд гараа өргөнө үү.

17-гоос 16 юу, хэд 12 уу? 17-гоос 12 гишүүн дэмжиж, Ариунзаяа гишүүн, таван жилийн үндсэн төлөвлөгөөг намрын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахыг дэмжлээ. Нэг дэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Одоо тэгээд 2 дахь асуудал чинь явах юм уу? Тэр микрофонууд ажиллах юм уу? Шалга даа наад микрофон чинь. Нэгийг нь асаагаадаа даа. Ажлын хэсгийн 6-г асаа даа. Ажлын хэсгийн 5, 6 аль нь ч яах вэ. 4 дээр дуугаа өг дөө. 6 дээр өг дөө. Аль нь асаад байгаа юм? Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг өг дөө. Болж байгаа юм байна.

10.37 цаг

Хоёр дахь асуудалдаа оръё. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.1-д Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр хуульд тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээллийг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлнэ. 115.2.11-д Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Төрийн байгуулалтын байнгын хорооны жил бүр хэлэлцэнэ гэж заасан.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан. Одоо ажилд орж байна уу микрофонууд чинь.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга Н.Монсор, Үндэсний зөвлөлийн гишүүн Ж.Цэсэн, Үндэсний. Зөвлөлийн гишүүн С.Алтанцэцэг, Үндэсний зөвлөлийн гишүүн Д.Оюун-Эрдэнэ ирээгүй юм уу? Энэ гишүүд ирсэн гээд нэр өгсөн юм байсан. Өөр Үндэсний зөвлөлийн гишүүн байна уу? Үндэсний олон нийтийн радио, телевизийн захирлын зөвлөл, Ерөнхий захирал Гэрэл, Тамгын дарга Батзаяа, Үндэсний телевизийн захирал Эрдэнэбат, Монголын үндэсний радиогийн захирал Бямбажаргал, Программ, бодлого зохицуулалтын газрын дарга Байгал, Техник, технологийн хөгжүүлэлтийн газрын дарга Сүхбаяр, Санхүү бүртгэл хөрөнгө оруулалтын газрын дарга Цэвэлсүрэн, Санхүү бүртгэлийн алба ерөнхий нягтлан бодогч Эрдэнэцэцэг, Монголын мэдээ сувгийн ерөнхий продюсер Баяржаргал, МҮОНРТ-ийн Хяналтын зөвлөлийн гишүүн Х.Энхбаяр, Хяналтын зөвлөлийн гишүүн Б.Баясгалан нарын гишүүн ажлын хэсэгт орж ирсэн байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж ажлын хэсгийг танилцууллаа. Одоо Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Үндэсний зөвлөлийн дарга Монсор танилцуулна. Монсор даргын ажлын хэсгийн 5 номерын микрофоныг өгье.

Н.Монсор: Эрхэм гишүүддээ энэ өдрийн амар амгаланг эрье. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга болон Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ бас баярлалаа. МҮОНРТ-ийн хувьд энэ анх удаагаа хуулийн дагуу танилцуулж байгаа тайлан. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн тайланг дараах агуулгын дагуу бид нар танилцуулах болно. Энд МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн ажил, хууль тогтоомжийн хэрэгжилт болон бусад асуудлууд.

МҮОНРТ нь 2024 оны төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Төсвийн нийт орлогыг 19 тэрбум 99 сая төгрөгөөр, нийт зарлагыг 25 тэрбум 577 сая төгрөгөөр төсвийн алдагдлыг 10 тэрбум 319 сая төгрөгөөр 24 онд баталсан. 24 оны 10 дугаар сард төсөвт тодотгол хийж санхүүд үүссэн алдагдлыг бууруулах эдийн засгийн нөхцөл байдлаас сэргээн төсвийн алдагдлыг 2024 оны 12 сарын 31-ний байдлаар 580 сая төгрөгийн алдагдалтай болгож, нийт өр, төлбөр, алдагдлыг 90 хувь хүртэл бууруулж чадсан ийм 24 он болсон. 24 оны санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэж тус алдагдал нь орсон байгаа.

МҮОНР-ийн Үндэсний зөвлөл нь хуулийн дагуу 11 эрх, үүргийг бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл нь үндсэн хэлбэр нь хурал байдаг. 2024 онд хуулийн дагуу хуулийн 24.1.7-гийн дагуу удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 24.1.7-гийн олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захиралд нэр дэвшүүлэх, томилох журмыг батлах гэж заасныг үндэслэн Үндэсний зөвлөлийн даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан МҮОНРТ-ийн ерөнхий захирлыг сонгон шалгаруулж, журмын дагуу нэр дэвшигчид нээлттэй сонсгол зохион байгуулан дэгийг Үндэсний зөвлөлийн 05 дугаар тогтоолын дагуу баталсан.

МҮОНРТ-ийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулалтад 10 хүн тухайн үед нэр дэвшсэн. Тэгээд энэ 10 хүнээс Гэрэл захирлыг сонгож, 2 дугаар шатад хамгийн өндөр оноо авснаар 2024 оны 3 сарын 25-нд Г.Гэрэл захиралтай МҮОНРТ-ийн Ерөнхий захирлаар томилж ажиллуулж эхэлсэн байгаа.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна. Удирдлага, бүтэц зохион байгуулалтын хувьд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 24.1.6-д олон нийтийн радио, телевизийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох гэж заасны дагуу байгууллагын засаглал шинэчлэлийн бодлогод үндэслэн МҮОНРТ-ийн зохион байгуулалтыг шинэчлэн баталсан.

2021 оны 12 дугаар сарын 15-нд Үндэсний зөвлөл нь 21 дүгээр тогтоолоор МҮОНРТ-ийн бүтцийн орон тооны дээд хязгаарыг 794 хүн байхаар тогтоосон байсан. Үүнийг 2024 оны 23 дугаар тогтоолоор 656-гаар тогтоож, нэгжийн бүтэц, орон тоог оновчтой болгож ингэж бууруулан баталсан байгаа.

23 оны Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 24.1.2-т олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үндсэн зорилт, стратеги төлөвлөгөө, тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэж Монгол Улсын төсөвт тусгуулах гэж байдаг. МҮОНРТ-ийн 2023 оны жилийн эцсийн тайлангаар НДШ-ийн өглөг 1.7 тэрбум төгрөг, хувь хүний орлогын албан татвах 1.5 тэрбум төгрөгийн өглөгтэй тэгээд мөн 2023 оны жилийн эцсээр 5.8 тэрбум төгрөгийн ийм ажил алдагдалтай ажилласан.

Тэгээд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 24.1.2-т заасан олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны үндсэн зорилт, стратегийн төлөвлөгөө, тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх Монгол Улсын төсөвт тусгуулах гэж заасны дагуу 2024 оны төсвийг хэт өндөр алдагдалтай батлагдсантай холбогдуулан үйл ажиллагааны зарим тэвчиж болох зардлуудыг хязгаарласан.

Үүнд гадаад, дотоодод томилолт. Өндөр дүнтэй үндсэн хөрөнгийн худалдан авалт гэдэг ийм зардлуудыг ер нь тэвчихээр тусгасан. Тэгээд мөн 2024 оны төсвийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарч ажиллах үүргийг гүйцэтгэх удирдлагад өгсөн. Мөн байгууллагад үүссэн нийгмийн даатгал болон ЭМД-ын өр төлбөрийг Монгол Улсын нэгдсэн төсөв, төсвийн тодотголд тусгуулан тусгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллах үүргийг өгч, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, төсвийн захиран зарцуулалт дээр хяналт тавьж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгон ажилласан.

Төсвийн хувьд 2024 он эхлэхэд бид нар төсвийнхөө орлогыг 19 тэрбум төгрөг, зарлагыг 25 тэрбум төгрөг, орлогоо 19 тэрбум төгрөг гэж төсөвлөсөн байсныг тодотгон 25.5 болгож, 33 хувиар нэмэгдүүлсэн. НДШ-ийн оны эхний өглөг нь 1.7 тэрбум төгрөг байж энэ ажилчин албан хаагчдын эрүүл мэнд, эмнэлэгт үзүүлэх энэ боломж бололцоо нь ер нь хаагдчихсан байсан. Энийг оны эцэс гэхэд бид нар 287.8 сая төгрөг болгож буюу 84 хувиар багасгасан. Мөн тайлант үеийн 5.8 тэрбум төгрөгийн алдагдал байсныг нь оны эцэс гэхэд 580 сая төгрөгийн алдагдал буюу 90 хувиар бууруулсан ийм үзүүлэлттэйгээр төгсгөсөн.

Энэ слайд дээр МҮОНРТ-ийн нийт орлогын бүтцийг та бүхэн харж болно. 24 оны төсвийн гүйцэтгэлийн нийт орлого 25.9 тэрбум төгрөг. Үүний дүнд 49.9 хувь буюу 12.9 тэрбум төгрөг нь улсын төсвийн дэмжлэгээр. Энэ маань өөрөө Олон нийтийн радио, телевизийн хууль дээр нөгөө орлогын дэмжлэг үзүүлэх төсөвт тусгаж дэмжлэг үзүүлнэ гэсэн заалтаараа орсон байгаа. 32.2 хувь буюу 8.5 тэрбум төгрөгийг болохоороо хураамжийн орлогоор. Энэ маань та бүхэн мэдэж байгаа. Бид нар айл иргэдээсээ, аж ахуйн нэгж, айл, иргэд, орон нутгаас хураамж авдаг. 16.2 хувь нь буюу 4.2 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны орлогоор олдог. Тэгээд 81 сая төгрөгийг норматив хувьсах зардлын санхүүжилтээр буюу тухайн үед “Эм Эн Би кидс” гээд энэ цэцэрлэг маань ажиллаж байсан. Бусад орлого буюу 128 сая төгрөгийг тус тус бүрдүүлсэн байна.

Нийт зардлын бүтцийн хувьд авч үзвэл энэ слайд дээр манай нийт зардал байгаа. 58 хувь нь буюу тухайн үед 794 ажилтан, албан хаагчийн цалин хөлс, НДШ байсан. Бусад үйл ажиллагааны зардлын хувьд 42 хувь байсан. Энэ бүх зардлуудыг та бүхэн харах юм бол байгууллага учраас томилолт, сургалт, уран бүтээлийн зардал гээд тэтгэмж, урамшуулал, үндсэн хөрөнгийн зардал гээд иймэрхүү зардлууд орчихсон явж байгаа.

Гүйцэтгэх удирдлага Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы хуралдаанаар МҮОНРТ-ийн 2.7 тэрбум төгрөгийн төсвийн тодотголоор төгрөгийг төсвийн тодотголоор оруулж, 1.2 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны орлогоор оруулж ирэх ийм ажлыг хүлээж авсан. Энэ маань өөрөө эргүүлээд нөгөө манай оны эхэнд үүсчихсэн байсан алдагдлыг бол ийм бууруулах зорилготой. Ингэснээр дээр дурдагдсан төсвийн орлого 33 хувиар нэмэгдэж, НДШ-ийн оны эхний өглөг буюу 1.7 тэрбум төгрөг байсныг 287 сая болгож оны эцсээр 84 хувиар буулгаж, тайлант үеийн алдагдлыг 90 хувиар бууруулсан ийм үзүүлэлттэй өнгөрсөн.

МҮОНРТ-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгууллагын салбар, нэгж бүрийн гүйцэтгэх ажлын чиглэл, зорилт, хүрэх үр дүнг нарийвчлан тусгаж нийт 2024 онд 221 ажил, арга хэмжээг төлөвлөсөн. Эдгээр нь байгууллагын хөтөлбөр, контентын чанар, техникийн шинэчлэл, хүний нөөцийн хөгжил, гадаад хамтын ажиллагаа, санхүү, үр ашиг гол чиглэлүүдийг бол хамарсан.

Үйл ажиллагааны төлөвлөгөөг баталснаараа МҮОНРТ 2025 онд мэдээллийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсын түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтоо хэрэгжүүлж чухал алхам болсон. Энд бас дурдахад энэ жил манайд Робокон мөн Эй Би Ю-гийн Женерал Ассамблей буюу одоо хэвлэл мэдээллийн АСЕМ гэхээр том арга хэмжээ зохион байгуулагдсан.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувьд хийгдсэн ажлууд гэвэл Үндэсний аудитын газар МҮОНРТ-ийн засаглалд оролцож буй этгээдүүдийн ажлын

уялдаагүй байдал, санхүүгийн эх үүсвэрийн дутагдлаас шалтгаалж байгууллагын хэвийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй байгаа тухай МҮОНРТ-ийн 2021-2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд тусгасан.

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг дурдсан хугацаанд нь Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үндэсний зөвлөл болон энэ гүйцэтгэх удирдлагад хүргүүлсэн байгаа.

Аудитын өгсөн зөвлөмжүүдийн хувьд гэвэл энэ дараах зөвлөмжүүдийг өгсөн. Үүнд хөтөлбөрийн бодлогод хяналт тавих, радио, телевиз, техник, технологийн сүлжээг хөгжүүлэх, техник хангамжийн бодлогыг тодорхойлох чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллах, эрх зүйн зөрчил тэй тогтоол шийдвэр гаргахгүй байх, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг нэмэх хэмжээг шинэчлэн тогтоох талаар тооцоо, судалгаа, үндэслэлтэй боловсруулан Засгийн газарт санал хүргүүлж шийдвэрлүүлэх. Энийг танилцуулгын эцэст бид нар дүгнэлт хэсэг дээрээ танилцуулах болно. Хяналт тавих чиг үүрэг бүхий бүтцийн нэгжүүдийн эрх зүйн байдлыг сайжруулах, үр ашигтай ажиллах тогтолцоог бүрдүүлэх, Үндэсний зөвлөлийн албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа, хууль дүрэм журамд нийцүүл ж хэрэгжүүлэх, гаргасан шийдвэрийг ил тод байдлыг хангаж ажиллахыг ингэж даалгасан. Энэхүү ажлын хүрээнд 2024 оны 6 дугаар сард Үндэсний зөвлөлөөс Өргөдлийг шалгах хороо Хяналтын зөвлөлд үүрэг болгож, сонгуулийн үеэрх нэвтрүүлгийн агуулгад мониторингийн судалгаа хийлгэх ийм үүрэг чиглэлийг өгсөн. МҮОНРТ-ийн 5, радиогийн 3 сувгийг хөтөлбөрийн бодлого нэвтрүүлгийн сүлжээг гүйцэтгэх удирдлагуудтайгаа хамтран нарийвчлан шинжилж баталсан.

Хөтөлбөр шинэчлэлийн хүрээнд нийт эфирийн цагийн 50 хувь нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлогыг хэрэгжүүлэх сүлжээний нэвтрүүлгүүд, 20 хувь нь шинээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд, 30 хувь нь давталтын хэлбэрээр үзэгч, сонсогчдод хүргэсэн.

Мөн Эйч Ди форматын дараах одоо хөгжил энэ формат болох 4К формат руу шилжих техникийн шинэчлэл хийхтэй холбоотой 4К форматын дэмжлэг хүртэл төхөөрөмжүүд сонгож байгаа бодлогыг шинэчлэн батлах ажил явагдаж байгаа.

Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох талаар тооцоо судалгаа, үндэслэлтэй боловсруулж Засгийн газарт санал хүргүүлж шийдвэрлүүлэх гэсэн ийм үүрэг даалгавар өгсөн. Үүнтэй холбоотой 2024 оны 1 дүгээр сарын 22-нд 22-ны 4 тоот болон 6 тоот албан бичгээр телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэх санал, санаачилга боловсруулан Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн.

Мөн 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 36 тоот албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайд үйлчилгээний хөлсийг хэмжээг нэмэгдүүлэх талаар хандсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд уг асуудал танилцуулагдаж хэлэлцэгдсэн болно.

Мөн 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн дугаар 75 тоот албан бичгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад мөн дахин хандсан болно.

Хяналт тавих чиг үүрэг бүхий бүтцийн нэгжүүдийн эрх зүйн байдлыг сайжруулж үр ашигтай ажиллах тогтолцоог бүрдүүлэх дээр Үндэсний зөвлөлийн

ажиллах журам нь 2022 онд батлагдсан бөгөөд уг журамд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн тул Үндэсний зөвлөлийн гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийн судалгаа, шинжилгээ хийх ажил гарсан. Журмын нэмэлт, өөрчлөлт дээр асуудлууд илүү тодорхой болж, үр ашигтай ажиллах тогтолцоог бүрдэнэ хэмээн үзэж байгаа. Үндэсний зөвлөлийн албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг хууль, дүрэм, журамд нийцүүлэн хэрэгжүүлэх, гаргасан шийдвэрийг ил тод байдлыг хангаж ажиллах, энэхүү зөвлөмж дээр Үндэсний зөвлөлийн хуралдаан бүрийн дараа олон нийтэд өөрийн цахим хуудсаараа хуралдааны шийдвэрийн мэдээг нийтэд мэдээлж байгаа. Мөн архив, албан хэрэг хөтлөлтийг хуулийн хүрээнд явуулж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор Үндэсний зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг мөн ажиллаж байгаа болно.

Бусад асуудал дээр болохоороо олон нийтийн радио, телевизийн хөтөлбөр хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих ажлын хүрээнд

2024 оны 11 тоот тогтоолоор МҮОНРТ-ийн сонгуулийн үеэрх нэвтрүүлэгт хяналт тавих зорилгоор хөндлөнгийн байгууллагаар шинжилгээ, үнэлгээ, мониторинг хийлгэхийг Хяналтын зөвлөл ДОюун-Эрдэнэд өргөдлийг шалгах хороо С.Алтанцэцэг нарт даалгасан. Энэ ажил маань 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Максима консалтинг”-тай захиалан ажиллах гэрээ хийгдэж эхэлсэн. “Максима консалтинг” нь 2024 оны 7 дугаар сард МҮОНРТ-ийн 1, 2 дугаар сувгийн агуулгын мониторингийн тайланг Үндэсний зөвлөлд хүргүүлсэн.

Зар сурталчилгааны тарифыг шинэчилсэн. МҮОНРТ нь 2015 онд Үндэсний зөвлөлийн 34 дүгээр тогтоолоор баталсан үнэ тарифыг мөрдөж байсан. Энэ хугацаанд инфляцтай уялдуулан олон нийтийн радио, телевизийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдаагүй МҮОНРТ-ийн төрөлжсөн 4 сувгийн онцлогт тохирсон үнийн саналыг тусгаагүй байсан. Тэгэхлээр энд нийгмийн сүлжээ, веб хуудас, дижитал ажил үйлчилгээний үнийн саналыг орхигдуулсан зэргийг Үндэсний зөвлөлөөрөө шинэчлэн батлуулж өгсөн.

Дүгнээд хэлэхэд Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл 2024 онд ажиллахдаа Үндэсний зөвлөлөөс ганц хүсэлт байгаа нь энэ Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасан байгаа энэ хураамжийг Засгийн газар баталдаг. Энэ хураамж маань өөрөө олон нийтээс авдаг энэ хураамж маань өөрөө та бүхэн түрүүн орлого дээр нь харсан. Энэ маань манай нийт зардалд маш бага хувийг эзэлж байгаа. Яагаад гэхлээр энэ хураамж маань өөрөө анхнаасаа батлагдсан өдрөөсөө хойш хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 66 дахин нэмэгдчихээд байхад манай энэ хураамжийн шимтгэл маань яг хэвээрээ байгаад байгаа. Энэ маань өөрөө эргүүлээд бид нарын одоо энэ МҮОНРТ-ийн хараат бус ажиллах, хараат бус үйл ажиллагаагаа явуулах, дээрээс нь олон улсад монголдоо энэ шинэ контент өв соёлтой холбоотой уран бүтээлийг бүтээх, дээрээс нь бид нарын энэ радиогийн 90 гаран жилийн алтан фонт, сан хөмрөг, архив, телевизийн 57, 8 жилийн энэ архивыг хадгалах, хамгаалах энэ ажил гээд гэх мэтчилэн маш олон ажлууд дээр маш их ингэж хүндрэлийг авчруулж авчирч байгаа. Тэгэхлээр дүгнээд хэлэхэд энэ дээрээ бид нар нэлээн их анхаарч ажиллах ёстой юм байна лээ Үндэсний зөвлөлийн хувьд. Магадгүй цаашдаа Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд ч гэсэн энэ өөрчлөлт орох шаардлага гарах байх.

Та бүхэнд анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Монсор даргад баярлалаа. Одоо олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг товч мэдээллийг Ерөнхий захирал Гэрэл дарга танилцуулна. Байнгын хорооны гишүүдийг бас Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг сонсоно. Гол үндсэн асуудал. Гэхдээ бас яг Үндэсний телевизийн захирал бас байгаа учраас мэдээллийг нь бас товчхон сонсчихъя гэж ингэж мэдээллийг бэлтгүүлсэн юм. Ажлын хэсгийн 6, хэд вэ 5 номерын микрофон уу, 6 номерын микрофон. Товч танилцуулна шүү.

Г.Гэрэл: Сайн байцгаана уу? Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. МҮОНРТ-ийн ерөнхий захирал Ганхуягийн Гэрэл. 2024 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэж байгаа энэ үед бид нар ямар хөтөлбөрийн бодлого голчилж чухалчилж ажилласан бэ, мөн өнөөдрийн байдлаар Үндэсний олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлогын үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа тухай товчхон тайлан, мэдээллийг хүргэе. Дараагийнх нь слайдыг тавьчих.

МҮОНРТ-ийн үйл ажиллагаа 2024 онд 4 дүгээр сарын 17-ны өдөр батлагдан гарсан Үндэсний аудитын 2021-23 оны үйл ажиллагааны тайлангийн гүйцэтгэлийн аудитын үр дүнгээс эхэлсэн гэж хэлж болно. Энэ бол Үндэсний аудитын батлагдсан тайланг бид нарт гардуулж өгсөн. Үүний дараагаар Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос энэхүү тайланг баталж, 5 дугаар сард бас чиглэл болгож энэ тайлангийн үйл ажиллагааг, тайланд тусгагдсан зүйлүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг даатгасан.

Энд харагдаж байгаа тайлан бол 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн одоо хүснэгт харагдаж байна. Энэ дээр оны эхний байдлаар -5.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан энэ үйл ажиллагааг 12 дугаар сарын 31-ний байдлаар -580 сая төгрөг болгон алдагдлаа бууруулсан энэ санхүүгийн тайланг үзүүлье. Мөн бид 2024-25 онд үйл аж ажиллагааныхаа нэвтрүүлгийн сүлжээг шинэчлэн баталсан ийм ажлыг зохион байгуулсан. Нэвтрүүлгийн сүлжээ гэдэг бол манай үйл ажиллагааны дотоод бүхий л зүйлийг хамарсан манай Үндсэн хууль үйлдвэрлэлийн гол технологи гэж хэлж болно.

2018 онд энэ сүлжээг баталсан байдаг юм. Телевизийн 5 суваг, радиогийн 3 суваг болон бусад сошиал платформ дээр явж байгаа үйл ажиллагаануудыг жигдэлж, салбар болгонд нь тохирсон нэвтрүүлгийн бодлогыг, сүлжээг баталж гаргасан. Энэ сүлжээг баталж гаргаснаар тухайн нэвтрүүлгийг хийж байгаа баг хамт олны тэр уран бүтээлд оролцож байгаа ажилтан, албан хаагч олны цалин болон нормын асуудлууд хүртэл энэ сүлжээг дагаж батлагддаг тул манай үйл ажиллагааны Үндсэн хууль гэж хэлж болно.

2024-2025 онуудад нэвтрүүлгийн давталт болон шинэ нэвтрүүлгийн хувь, хэмжээ ямар байгааг энэхүү слайд дээр товчхоноор үзүүлэх гэсэн юм. 24 оны 1 дүгээр улиралд шинэ нэвтрүүлгийн оролцоо 2 дугаар улиралд дээшилсэн нөхцөл байдалтайгаар харагдаж байна. 3 дугаар улиралд 8, 7 сар ордог учраас амралтын үе тохиож шинэ нэвтрүүлгийн хувь оролцоо буурсан. Харин 4 дүгээр улиралд энэ шинэ хөтөлбөрийн бодлогыг бид нар илүү тогтмолжуулж 25 оны 3 дугаар улирал хүртэл энэ нэвтрүүлгийн шинэчилсэн байдлыг хадгалсаар ирсэн байна.

Редакцын бодлогоор ямар ямар үйл ажиллагаа явуулж байгаа вэ. Үндэсний олон нийтийн радио, телевизийн шинэ нэвтрүүлгүүд хэд хэдэн хувиараа ингэж ангилагдаж байгаа вэ гэдгийг эндээс харж болно. Мэдээ мэдээлэл 32 хувь, Үндэсний спорт 6 хувь, Эм Эн Би Ворлд буюу Монгол Улсыг гадаадад сурталчлах

нэвтрүүлэг мэдээ, мэдээлэл 7 хувь, гаднын гэрээт нэвтрүүлэг хуулийн дагуу 2 хувь, хүүхдийн нэвтрүүлэгт хүүхдэд зориулсан нэвтрүүлэг тусдаа 8 хувь, түүх, өв уламжлал, соёл түүхтэй холбоотой нэвтрүүлгүүд 8 хувь байна. Шинжлэх ухаан, залуучуудад зориулсан нэвтрүүлгүүд 7 хувь, нийгмийн шинж чанартай цаг үеийн нэвтрүүлгүүд 8 хувь, өглөөний нэвтрүүлэг болон чөлөөт хөтөлбөр 11 хувь, кино, орчуулгын нэвтрүүлгүүд 10 хувийг эзэлж байна манай хөтөлбөрийн бодлогод. Эдгээрийг хүснэгтэд харуулсан.

2024 оны үйл ажиллагаан дээр онцлох контент, нэвтрүүлгүүд юу байсан бэ гэвэл бид нар энэ шинэ удирдлагын баг томилогдоод нээлттэй өдөрлөгийг хагас сарын туршид зохион байгуулсан. Энд бол олон нийтээсээ мэдээ, мэдээлэл авч, олон нийтийнхээ санал бодлыг хөтөлбөрийнхөө бодлогод тусгах, энэ шинэ хөтөлбөрийн сүлжээгээ хийхэд энэ өдөрлөг арга хэмжээнүүд их чухал үүрэг гүйцэтгэсэн. 2024 он Улсын Их Хурлын сонгууль болон орон нутгийн сонгууль одоо болсон ийм онцлог жил байсан.

Ялангуяа 2024 оны тухайтад бид нар Сонгуулийн тухай хуульд шинээр заасан нэвтрүүлгүүдийг, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх мэдээ, мэдээлэл, тусгайчилсан нэвтрүүлгүүдийг болон энэ мэтгэлцээнийг зохион байгуулах шинэ ийм хуулийн хүрээнд ажилласан.

Үндэсний их баяр наадмын шууд дамжуулалтууд болон Үндэсний их баяр наадмын үйл ажиллагааг дамжуулах, эх орон даяар үзүүлэх, мөн сошиал аппликэйшн дээр Эм Эн Би-ийн эфирийг үзүүлдэг болсон ийм амжилттай болсон.

2024 оны 9 сарын 1 бол Үндэсний радио үүсэн байгуулагдсаны 90 жилийн ой тохиосон. Энэ 90 жилийн ойгоор ойг тохиолдуулах арга хэмжээг зохион байгуулж, мөн одоо энэ радиотой холбоотой үйл ажиллагааг олон нийтэд дахин танилцуулах энэ зүйлийг хийсэн.

Робокон гээд үндэсний аварга шалгаруулах тэмцээнийг бид нар 24 ондоо хийж, 25 ондоо олон улсын аваргыг зохион байгуулсан. Нүүдэлчин соёлын наадмыг бид нар шууд дамжуулан эх орон даяар үзүүлсэн. Халх голын байлдааны ялалтын 85 жилийн ойн арга хэмжээг Батлан хамгаалах яамтай хамтран шууд дамжуулах улс эх орон дээрээ даяар баярын хөтөлбөрүүдийг зохион байгуулах энэ ажлуудыг зохион байгуулсан. Ай Би Си Си 2024 гээд олон улсын өргөн нэвтрүүлгийн үйлдвэрлэлийн одоо чуулга уулзалтад оролцож бид нар энэ гадаад контентуудаа сэргээж ажилласан юм. Энэ нэвтрүүлэг. мэдээ мэдээлэл, баримтат кино, танин мэдэхүйн чиглэлийн нэвтрүүлгүүд болон үзэгчдийг зугаацуулах оройны гэр бүлд зориулсан энэ цагт зориулсан гадаадын орчин үеийн кино, контентуудыг авч орчуулан түгээх, орчуулан хүргэх энэ ажлуудыг хийсэн.

Товчхон мэдээллүүдийг хүргэхэд би телевизийн 5 суваг үйл ажиллагаа явуулж байгааг анхлан эрхэм гишүүдэд дуулгасан. Тэгвэл 2 дугаар суваг маань Монголын мэдээ суваг байгаа. Шинэ нэвтрүүлгийн бодлого нь, Монголын мэдээ сувгийн нэвтрүүлэг 52 хувиар шинэчлэгдэн зохион байгуулагдсан байна. Доторх нэвтрүүлгийн бүтцийг та бүхэнд харуулж байна. Үндэсний спортыг сурвалжилдаг Үндэсний спорт Эм Эн Би Спорт суваг маань, шинэ нэвтрүүлэг давталт нь 39 хувьтай, шууд дамжуулалт 39 хувьтай, үлдсэн нь шинэ нэвтрүүлгийн тоо хэмжээг харуулж байна.

Ц.Сандаг-Очир: Хугацаа дууссан байна. Баярлалаа. Үндэсний зөвлөлийн тайлан болоод телевизийн үйл ажиллагааны товч мэдээллийг сонслоо.

Хийсэн тайлан, мэдээллүүдтэй холбогдуулаад гишүүд асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Хуруугаа уншуулаад орно гэж байна. Энэ системийн, техникийн гацалт үүсчхээд байгаа юм байна угаасаа. Нэрсээ өгсөн үү яаж, болох юм уу болохгүй юм уу. Нэрээ яаж өгөх юм? Түр хүлээж байгаарай. Орчихлоо. Болж байна. Одоо орж байна. Нэрсээ өгөөрэй.

Энхтуяа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн. Одоо орж ирж байна. Номин гишүүнээр. Ирцээрээ одоо орж ирж байна. Тийм уг нь Энхтуяа гишүүн хамгийн түрүүн ирсэн дээ. 8.59-д. Одоо зөв үү? Үгүй ээ, Энхтуяа дарга, Энхтуяа гишүүн бүүр Лодойгоос ч өмнө ирсэн юм. Энэ яг ирцийнхээ дарааллаар орохгүй л байна даа. Тэгсэн Ганбаа гишүүн бид гурав 1, 2, 3 гээд ирсэн тээ. Техникийнхэн хааччихав өө нөгөө Энхтуяа гишүүн ч байхгүй болчихлоо. Бүүр өө асуулт нь эхэлчихсэн явж байна шүү. Таных эхэлчихсэн явж байна шүү дээ. Шинээр өгье. Энхтуяа гишүүний цагийг шинээр өгье.

Д.Энхтуяа: Та бүхэндээ энэ өглөөний мэнд хүргэе. Тайлан, 2 тайлан сонсчих шиг боллоо. Гүйцэтгэх удирдлагын тайланг 2 сонслоо. Тэгэхээр ер нь бид нарт өгсөн энэ юугаар хэд хэдэн зүйлүүдийг бас тодруулъя гэж бодож байна. Энэ тайлан дээр саяын өгсөн гүйцэтгэх удирдлага 2 удаа гүйцэтгэх удирдлагын тайлан гэдгийг би дахиж хэлье. МҮОНРТ нь үйл ажиллагааны тайланг цахим хуудсандаа байршуулаагүй байна гэсэн ийм байна. Мөн тайлангийн хувьд дээр дурдсан мэдээллүүдийг тайландаа тусгаж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаагүй байна. Шилэн дансны мэдээллийг цахим хуудсандаа байршуулаагүй байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Мөн асуудал Үндэсний олон нийтийн радио, телевизийн одоо үйл ажиллагаатай холбоотой 40.40 хувийн ийм төлөвлөсөн ажлыг Үндэсний олон нийт радио, телевизийн Үндэсний зөвлөлөөрөө бас хэлэлцээгүй байна. Хяналтын зөвлөлөөс 20 асуудлыг Үндэсний зөвлөлийн хуралдаанд оролцуулж хэлэлцүүлснээс 8 асуудлыг хэлэлцээгүй байна гээд бид нарт ирсэн мэдээллээр ерөнхийдөө энэ хуулийн хэрэгжилтийг маш сайн хангаагүй байна гэсэн ийм тайлан ирсэн байна. Өнгөрсөн 4 жилд улсын төсвөөс үзүүлсэн 30 гаруй тэрбум төгрөгийн дэмжлэгт Үндэсний аудитын газраас тогтмол аудит хийгдээгүй байна гээд ийм ийм бид нар дүгнэлтийг Аудитын газраас танаад өгсөн байна.

Тэгээд Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл Төрийн байгуулалтын байнгын хороонд тайлангаа тавих ёстой. Бид нар гүйцэтгэх удирдлагын тайлан энд сонсох шаардлага байхгүй гэж ингэж бодож байна. Ингээд яг энэ саяын бид нарт танилцуулсан тайлангаа Үндэсний зөвлөлийнхөө хэдэн сарын хэдний хурлаар хэлэлцүүлж, хэдэн хувийн саналаар энэ тайлангаа та бүхэн баталсан бэ нэгдүгээр энэ Үндэсний зөвлөлийн даргаас асууж байна.

Хоёрт нь энд хяна 2 бас Хяналтын зөвлөл болон Өргөдлийг шалгах хороо гэсэн ийм 2 бүтэц энэ Үндэсний зөвлөл дотор байгаа гэж ингэж ойлгож байна. Тэгэхээр Хяналтын зөвлөлийн дарга нь ирсэн байгаа билүү? Ирсэн. Өргөдлийг шалгах хорооны дарга нь хэн билээ байгаа юу ирсэн байгаа юм байна тээ. Тэгэхээр Хяналтын зөвлөлийн яг энэ саяын өгсөн тайланг Хяналтын зөвлөлөөр руу оруулж ямар бас тайлангийн ийм юу гаргасан бэ, дүгнэлт гаргасан бэ? Та бүхэн энэ дүгнэлтдээ саяын гаргасан энэ зөвлөмж юуг хүлээн зөвшөөрч, энэ хэдэн

сарын ямар хурлаараа ямар зөвлөмж гаргаж хэлэлцүүлсэн бэ? Энэ дээр Хяналтын зөвлөлийн хариултыг сонсьё. Яагаад ингэж асууж байна гэвэл энэ санхүүгийн дүгнэлт дээр маш олон бас зөрчилтэй зүйлүүд гарсан байна. Энэ сүүлийн 4 жил хэлэлцээгүй байна гээд.

Ц.Сандаг-Очир: Дараа нь тодруулчих уу? Дараа нь тодруулах минутаа авъя гэж байна. Монсор дарга хариулаара Энхтуяа гишүүний асуултад. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Н.Монсор: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Үндэсний зөвлөлийн хувьд хэлбэр нь өөрөө хуралдаан байдаг. 40.4 хувийн хэлэлцсэн байна гээд тэгж хэллээ. Энэ бол та бүхэн тайлан дээр харсан байх 2024 онд 3 удаа хуралдсан. Үүнээс ээлжит хуралдаан 1 удаа, ээлжит бусаар бусад хуралдаануудыг нь хуралдсан. Үүнд 47 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байснаас 19 асуудлыг хойшлуулж, нийт 13 хуралдаанаас 25 тогтоол, шийдвэр гарсан.

Гишүүдэд очсон энэ тайлан дээр миний Үндэсний зөвлөлийн даргын хувьд өгөх тайлбар бол энэ хуралдаанд оруулж ирж байгаа материалыг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиараа хурал хуралдах санаачилгыг, товыг Үндэсний зөвлөлийн дарга товлон. Эсвэл бүх Үндэсний зөвлөлийн гишүүдийн 3-ны 1 буюу 5 гишүүн санаачилга гаргаж байж хуралдуулдаг байгаа. Тэгээд энэ хойшлуулсан асуудлын хувьд энэ тухайн өдөр дэгийнхээ дагуу хуралдаанд оруулж ирээд хэлэлцэх гэж оруулж ирсэн асуудлыг гишүүдийнхээ олонхоороо хойшлуулъя, энийг хэлэлцэхгүй ээ гэсэн саналтай байгаад тэгж шийдэгдсэн. 24 оны тайлан бол 4 сард хүргэгдсэн.

Ц.Сандаг-Очир: Таны наад энэ тайлан Үндэсний зөвлөлөөрөө хэлэлцүүлсэн юм уу гэж Энхтуяа гишүүн маш тодорхой асуусан.

Н.Монсор: Хэлэлцэх асуудлын дараалалд орсон байгаа.

Ц.Сандаг-Очир: Айн юу яриад байнаа? 24 оны тайлан юм ярьж байхад ирүүлсэн байгаа гэж ирээдүй цаг дээр яриад байх юм. Үндэсний зөвлөлөөрөө энэ тайлангаа хэлэлцүүлсэн юм уу?

Н.Монсор: Энэ 24 оны энэ асуудлыг хэлэлцэх асуудлаа оруулаад тэгээд тухайн үед энэ хуралдаан маань хойшлогдчихсон байгаа энэ асуудлыг, хэлэлцэх асуудал маань.

Ц.Сандаг-Очир: Одоо болтол Үндэсний зөвлөлөөрөө тайлангаа хэлэлцээгүй яваа юм уу Монсор даргаа? Та чинь ер нь ажлаа мэдэж байна уу, мэдэхгүй байгаа юм уу? Одоо болтол хэлэлцээгүй яваа юм уу Үндэсний зөвлөлөөрөө? Тэгээд бид нарт Төрийн байгуулалтын байнгын хороогоор Их Хурлын гишүүдэд Үндэсний зөвлөлийн тайлангаараа тайлангаа хэлэлцүүлээгүй тайланг энд хэлэлцүүлээд байгаа юм уу? Та тодорхой хариул даа. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Н.Монсор: 4 сард энэхүү тайланг аваад хөндлөнгийн аудит маань тайлангаа аудитынхаа дүгнэлтийг 6 сард хүргүүлээд тэгээд бид нар тэрнээс хойш хуралдах гээд тэгээд энэ маань хойшлогдчихсон байгаад байгаа.

Ц.Сандаг-Очир: Энхтуяа гишүүн тодруулъя.

Д.Энхтуяа: Энэ бас хэлэлцээгүй тайланг бид нар хэлэлцэх ийм шаардлага ийм юу байгаа юу дэгт? Энэ МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл ажлын тайлангаа Төрийн байгуулалтын байнгын хороонд тайлагнана гээд. Тэгэхээр Үндэсний зөвлөлийн хамтын шийдвэрээр хэлэлцэж баталсан тайланг Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэнэ ээ гэж ингэж ойлгож байгаа. Тэгэхээр яг энэ би түрүүн хэлээд байгаа нь гүйцэтгэх удирдлагын тайланг бид нар сонсох ямар ч шаардлага байхгүй. Гүйцэтгэх удирдлага нь Үндэсний зөвлөлдөө бүх тайлангаа тавиад тэгээд хэлэлцэгдсэн тайланг бид нар энд одоо хэлэлцэх ёстой учраас энэ дэгийн хуулийг зөрчиж байна гэж би бас харж байна.

Хоёрт нь тэр Хяналтын зөвлөлөөс асуусан Хяналтын зөвлөлөөрөө энэ тайлангаа оруулсан юм уу?

Ц.Сандаг-Очир: Монсор дарга юу болж байна? Бид нар цаг хугацааны хувьд хожуу сонсож байгаа нь үнэн. Түрүү 7 хоног товлогдсон байсан. Таны тайлан хангалтгүй байсан. Ахиад тайлангаа чамбайраад ирээд авчраад хэлэлцүүлэе ээ гэсэн. Одоо тавьж байгаа тайлан чинь Үндэсний зөвлөлдөөд тайлангаа танилцуулаагүй, баталгаажуулаагүй ийм тайланг энд оруулж ирээд одоо ингээд хойшлогдсон гээд ямар учраас хойшлогдсон юм тэгвэл, яагаад тайлангаа авч хэлэлцдэггүй юм? Үндэсний зөвлөл чинь тэгвэл ажлаа хийж байгаа юм уу? Үндэсний зөвлөл чинь ажлаа хийж байгаа юм уу, яагаад өдий болтол тайлангаа дотроо хэлэлцэхгүй байгаа юм. Түрүүн та хэлсэн 13 удаа хуралдсан байна. 1 удаа ээлжитээр, 12 хуралд нь ээлжит бусаар 19 хэлэлцэх асуудлыг хойшлуулсан байна гээд байна. Яагаад асуудлуудаа хэлэлцэхгүй ингээд ямар ч учир шалтгаанаар энэ олон асуудлуудыг цаг хугацаанд нь хэлэлцэхгүй хойшлуулаад байдаг юм. Тэр хойшлуулаад байсан асуудлууд чинь гол нь дандаа тэр төсөв санхүүтэй, тайлантай, нягтлангийн үйл ажиллагаатай холбоотой, төлөвлөгөөтэй холбоотой, санхүүгийн төлөвлөгөө хяналт шалгалтын дүнтэй холбоотой асуудлууд байна лээ шүү дээ. Тэгээд яагаад энэ асуудлуудаа хэлэлцдэггүй юм цаг хугацаандаа. Тэгээд гишүүд асуугаад байна шүү дээ. Яагаад ингээд хэлэлцүүлээгүй тайланг энд одоо хэлэлцүүлээд байгаа юм гээч. Үндэсний зөвлөлөөрөө яагаад авч хэлэлцэхгүй байгаа юм? Ямар шалтгаан байсан юм? Та хэл дээ Монсор дарга аа? Яачихсан тайлан байсан юм, яагаад хэлэлцэхгүй байсан юм?

Н.Монсор: Тухайн үед тайлан бол ороод ирсэн. Тайлан бол бэлтгэгдчихсэн. Тэгээд ирц нь бүрдээгүй юм. Яагаад гэхлээр угаасаа хурал зарлаад тодорхой шалтгаанаас болоод ирц бүрдэж амжаагүй.

Ц.Сандаг-Очир: Тайлбар болоо юу тээ. Ирц бүрдээгүйгээс ингээд бүтэн л жилийн хугацаанд шүү дээ. Энхтуяа гишүүн ахиад тодруулъя.

Д.Энхтуяа: Төрийн байгуулалтын байнгын хорооноос бид нар Үндэсний зөвлөлийн гишүүдийг сонгож шалгаруулж явуулж байгаа. Тэгэхээр одоо бас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хугацаа нь дууссан гишүүдийн орох орон тооны асуудал бас орж ирээд хүмүүс өргөдлөө өгчихсөн байгаа. Тэгэхээр ер нь энэ Үндэсний зөвлөлийн зовлонгийн асуудлыг бид нар энд ярих ёстой байхгүй юу. Тэгэхээр Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа доголдоод байна уу? Засаж сайжруулах юм юу байна? Одоо ингээд жишээлбэл бид нар хүмүүс томилоод л ингээд явуулчихдаг. Тэгээд тэнд бас Үндэсний зөвлөл энэ Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн хэвийн үйл ажиллагааг, санхүүгийн үйл ажиллагааг, бодлогын үйл ажиллагааг одоо чиглүүлэх ёстой гэж ингэж ойлгож

байгаа юм. Тийм учраас бид нарт бас сонгож явуулсан хүмүүс маань учир дутагдалтай ажиллаад байна уу энийг хариулах хүн байна уу? Тэгэхээр одоо яг ингээд гарсан орон тоон дээр бас шинээр томилж явуулах гээд байна шүү дээ бид нар. Энэ дээр хариулах Үндэсний зөвлөлийн гишүүн байна уу?

Ц.Сандаг-Очир: Үндэсний зөвлөл гэж Хяналтын зөвлөл гэж байгаа. Хяналтын зөвлөл байгаа.

Д.Энхтуяа: Энэ бид нарт огт хэлэлцэгдээгүй ийм юуг оруулж ирж байна шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Хяналтын зөвлөл гэж байна уу? Ажлын хэсгийн 3 номерын микрофон. Та хяналтаа тавьж байна уу, танай Үндэсний зөвлөл ажлаа хийж байна уу, асуудлаа хэлэлцэж байна уу? Та хариулаадах Энхтуяа гишүүний асуултад. Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

Д.Оюун-Эрдэнэ: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Хяналтын зөвлөл хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэх удирдлагын тайланг сонсож, дүгнэлт гаргаж хэлэлцдэг, тэрийг Үндэсний зөвлөлд оруулдаг. Үндэсний зөвлөлийн тайланг хэлэлцэнэ гэсэн тийм боломж байхгүй хууль, эрх зүйн хувьд тусгаагүй байдаг. Ер нь энэ 24 оны тайлан хэлэлцэж байгаатай холбоотойгоор бид нар бас хяналтын зөвлөлөөр гүйцэтгэх удирдлагын тайлан хэлэлцэгдээгүй байгаа. Одоо Энхтуяа гишүүний 2 дахь асуултад хариулахад Үндэсний зөвлөлийн гишүүд салбар болгоны төлөөлсөн, мэргэшсэн ийм төлөөлөл байх ёстой. Энэ үүргийг бас яг энд хуулийн заалт бас тодорхой хэмжээнд хэрэгжихгүй байгаа энэнээс үүдэлтэйгээр бас Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа бас доголдох одоо яг удирдлагаар, менежментээр хангах тийм боломж хязгаарлагдмал болсон гэдэг ийм дүгнэлттэйгээр Хяналтын зөвлөл ер нь ажиллаж байгаа.

Өнгөрсөн хугацаанд Хяналтын зөвлөл 24 оны байдлаар 7 удаа хуралдаад 20 дүгнэлт гаргасан байгаа. Энэ 20 асуудлын ихэнх нь үйл ажиллагааны.../минут дуусав./

Ц.Сандаг-Очир: 1 минут гүйцээгээд хариул. Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

Д.Оюун-Эрдэнэ: Хяналтын зөвлөл хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд 7 удаа хуралдаж, 20 асуудлыг хэлэлцэхдээ Үндэсний аудитын газрын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу бас хяналт тавьж ажилласан байгаа. Одоо энэ дээр мөн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Энэ дагуудаа 7 дүгнэлт гаргаж, Үндэсний зөвлөлд оруулсан. Тэгээд тодорхой хэмжээгээр бид нар бас зөвлөмж өгөх үүрэгтэй байдаг. Энэ зөвлөмжийнхөө дагуу бас хураамжийн орлогыг нэмэгдүүлэх реклам, зар сурталчилгааны тарифыг Үндэсний зөвлөл хэлэлцүүлж батлуулах одоо гишүүдийн бас ёс зүйн асуудлыг хэлэлцэх, ирц бүрдээгүйтэй холбоотойгоор гишүүдийн урамшуулал өгдөг. Урамшууллыг бас ирцэд нь одоо ингэж уяж өгөх ёстой гэдэг ийм зөвлөмжийг өгч байсан. Гэвч энэ асуудал маань хэлэлцээгүй байгаа.

Ц.Сандаг-Очир: А.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

А.Ганбаатар: Өнөөдөр 24 оны Монголын үндэсний радио, телевизийн тайланг хэлэлцэж байгаа юм байна. Ер нь 24 оны юмыг 25 оны сүүлээр хэлэлцэнэ

гэдэг чинь хожуу хэлэлцэж байна гэсэн үг. Гэхдээ анх удаа гэдэг нь сайшаалтай. Ер нь МҮОНТ нь олон нийтийн болсны гол зорилго бол манай нийгмийн бүх эко системийн иж бүрдэл болсон энэ хүмүүсийн төлөөлөл удирдах зөвлөлд нь суугаад, энэ хүмүүс бодлогоо гаргаад МҮОНТ-ээр үндэстэн олноо соён гэгээрүүлэх, мэдлэг, мэдээллээр хангах ийм л чиг үүрэгтэй. Маш товчхон хэлэхэд одоо Эн Эйч Кэй, Би Би Си, Дойче Вэйлий зэрэг зиндаанд хүрэх ийм зорилт тавьж явах ёстой, улс төрөөс ангид байх ёстой гээд. Миний гарт болохоор Глоб интернэйшнлийн МҮОНТ-ийн үйл ажиллагаанд хийсэн ийм мониторинг байж байгаа юм. Эндээс эхлээд 3 асуулт асууя гэж бодож байна.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 8.5 дээр зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг Үндэсний зөвлөл дэргэдээ байгуулна гэсэн. Тэр нь одоогоороо байгуулагдаагүй байгаа юм байна. Гаднын жишээг дурдахад Би Би Си, Эн Эйч Кэй 2 одоо 110 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй ийм зөвлөх үйлчилгээ бүхий зөвлөл байдаг юм байна. Энэ байна уу? Ийм зөвлөх үйлчилгээ бүхий зөвлөл байна уу гэж. Нэгд нь.

Хоёрт нь Удирдах зөвлөлөөс нөгөө Хяналтын зөвлөлдөө Удирдах зөвлөлөөсөө гишүүдээ томилчихсон байна гээд байна л даа. Энэ үнэн юм уу? Удирдах зөвлөлөөсөө Хяналтын зөвлөлөө томилохоор нөгөө манаачийг хэн манах вэ гэгчээр өөрөө өөрийгөө хянах үйл ажиллагаагаа хянах ийм бүтэц, бүрэлдэхүүн хийчихсэн нь үнэн юм уу гэж асууж байгаа юм.

Гуравд нь энэ ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдэхдээ цалин пүнлүүг нь нөгөө 40 хүртэлх хувиар ингээд тодорхой шийдвэр үндэслэлгүйгээр хасчихсан байна гээд. Үндэсний радио, телевизэд ажиллаж байгаа ажилчдын буруу гэж байхгүй. Бүгд мэргэжлийн хүмүүст ажилладаг гэж ойлгодог. Тэгэхээр энэ цалин пүнлүүнийхээ бодлогыг яаж барьдаг юм бэ, үндэслэлтэй хасаж байгаа юм уу хасахгүй байгаа юм уу гээд.

Дөрөв дэх асуулт нь сая орлогын бүтцээ харуулж байна лээ. Орлогын бүтэц дотор төсвийн татаас байж байгаа, 50 хувийг нь бүрдүүлж байгаа, нэвтрүүлгээ зарж байгаа юм байна. Нэвтрүүлгийн орлого байгаа. Хуулийн дагуу 2 хүртэлх реклам, сурталчилгаагаа олж байгаа байх. Орлого олох тал дээр Олон нийтийн радио, телевизийн хуульд хийх өөрчлөлтийн санал байна уу? Тухайлбал би Монгол телевизийн өөрөө том савтай байр учраас хувийн бодлоо хэлэхэд ийм контент үйлдвэрлэдэг газруудын кластер болгоод байраа түрээслээд, сайн контентуудыг аваад, тэрийгээ үнэлээд давхар зараад ингээд орлогоо бүрэн бүрэлдүүлэх боломжтой гэж үздэг. Санал дээрээ би бас саналаа хэлье. Тэгэхээр орлогоо хэрхэн нэмэх, бүрэлдүүлэх тал дээр хуулийн хүрээнд санал байна уу гэж ийм хэдэн асуултыг эхлээд асуугаадахъя.

Ц.Сандаг-Очир: Ганбаатар гишүүний асуултад ажлын хэсгийн 5 номерын микрофон. Монсор дарга хариулъя.

Н.Монсор: Нэгдүгээр асуултад Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар орон тооны нөгөө зөвлөл байгуулах гээд ба олон нийтийн зөвлөл гээд байгаа. Энэ маань байгуулагдаагүй.

Хоёр дахь асуултад болохоороо Үндэсний зөвлөлөөс Хяналтын зөвлөлөө томилсон нь үнэн үү гээд. Манай шинэ журмаараа Үндэсний зөвлөлийн дэргэдэх Хяналтын зөвлөл маань, Хяналтын зөвлөлийн ажиллах журам 2022 онд

батлагдсан шинэ журам. Тэгээд Хяналтын зөвлөл маань 3 хүний бүрэлдэхүүнтэй. 3 хүний маань 2 хүн нь, 2 гишүүн нь гаднаас байдаг. 1 гишүүн маань манайх дотроосоо Үндэсний зөвлөлийн 1 гишүүн бөгөөд тэр хяналтын зөвлөлийнхөө даргыг хийдэг.

Гурав дахь асуултад энэ цалинтай холбоотой асуулт байна. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл бол тухайн жилийнхээ энэ төсвийг ингээд батлаад энэ дээрээ бүх ажилчин, албан хаагчдынх нь ингээд албан тушаалаар нь бүтцийн дагуу цалинг нь баталдаг. Энэ дээр тэр 40 хувийн хасагдлыг би мэдэхгүй байна. Энэ гүйцэтгэх удирдлага илүү их хариулах байх. Яагаад гэхлээр нөгөө өдөр тутмынх нь үйл ажиллагаатай холбоотой учраас. Орлогын бүтцийн хувьд 3 үндсэн орлогын бүтэц байгаа. Нэг нь болохоороо хураамжийн орлого, төсвийн дэмжлэг, уран бүтээл гэж байгаа. Уран бүтээлийн хувьд манайх нийт эфирийн цагийн 2 хувь хүртэл гэж байгаа. Түрүүн бид бүхэн дурдсан энэ 2015 оноос хойш анх удаагаа 2024 онд бид нар энэ тарифыг нэмэгдүүлсэн байгаа. Яагаад гэхлээр энэ инфляцтай холбогдуулаад.

Гэхдээ энэ орлого дээр тодорхой хэмжээний цензур байдаг. Яагаад гэхлээр үндэсний хэмжээний ийм олон нийтэд үйлчлэх ёстой байгууллага учраас тодорхой цензурүүдийг тавьсан байдаг. Орлогын өшөө нэг санал дээр тэр хуульд өөрчлөлт оруулаад юу яахыг бид нарт саналууд байгаа. Гишүүнд бид нар Үндэсний зөвлөлөөрөө бас ярьж байгаад албан бичгээр бас хүргүүлж саналаа хүргүүлье. Ийм байна.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу, зүгээр үү? Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүд, Үндэсний зөвлөлийнхөө гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдсан. Одоо ингээд даруй 20 жил өнгөрч байна л даа. Бидэнд их томоохон хүлээлт байсан байх тэр үед. Тэр хүлээлтийн нэг хэсэг нь биелсэн, нэг хэсэг нь янз янзын сорилттой тулгарч л байгаа байх. Угаасаа сорилтгүй нийгэм гэж байхгүй юм чинь тулгарах ёстой. Гэхдээ анхнаасаа бидний тавьсан зорилго ер нь хэр биелж байна вэ гэдгийг анх удаа та бүхэн бидэнд тайлагнах гэж байгаа юм байна.

Тэгэхээр энэ дээр бид бие биетэйгээ илэн далангүй ярьж тэгээд Үндэсний зөвлөл маань өөрийнхөө санал, зөвлөмжийг одоо эндээс гаргаж, тэгээд Их Хурал эндээс ер нь цаашдаа юу хийх вэ, ямар байдлаар бид жишээ нь эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох вэ гэдэг ийм л зүйл яригдах ёстой. Тэгэхээр энэ талаас одоо бас би Их Хурлын гишүүддээ бас хандаасай гэж бодож байна. Бид ямар нэгэн ажил одоо жишээ нь хянаж шалгах гэж байгаа биш. Энэ том бодлогын асуудлыг харилцан ярилцаж цаашдаа яаж шийдэх вэ гэдэг дээр л ийм хуралдаан болж байгаа шүү гэдгийг бас би гишүүний хувьд та бүхэнд бас санал болгож байна.

3 асуулт байна. Эхний асуулт хууль батлагдчихлаа 20 жил хэрэглэчихлээ. Тэгээд энэтэй холбоотой Үндэсний олон нийтийн радио, телевизийн хөтөлбөр, хөтөлбөрийн жишээ нь бодлого, энийг хэрэгжүүлэх зохион байгуулалт, бүтэц менежмент гэдэг юм уу энэ бүх зүйл дээр энэ ямаршуу сорилтууд байна, энэ дээр та бүхэн ямар саналтай байна гэдэг ийм асуулт байна. Энийг л бид нар сонсож байж, эндээс бид нар энэтэй холбоотой энэ шийдэл хийх, эсвэл бид бас давхар үүрэг авна шүү дээ даалгавар авна. Энийгээ яримаар байна нэгдүгээр асуудал.

Хоёр дахь асуудал мэдээж хэрэг энэ жишээ нь Үндэсний хороо, Үндэсний үндэсний зөвлөл дотор бас тодорхой Хяналтын хорооноос гадна энэ орон тооны бус зөвлөл байгаа юм. Энэ мэргэжлийн зөвлөл нь юм. Энэ энэ Үндэсний хороод дотор ийм орон тооны бус зөвлөлүүд байдаг гол зүйл мэргэжлийн шийдвэр гаргахад Үндэсний зөвлөлд дэмжлэг үзүүлдэг юм байгаа юм. Тэгэхээр энэ зөвлөл ер нь хэр ажиллаж байна? Энийг та бүхэн бас бидэнд хэлээч ямар үр дүнгүүд гарч байна гэж?

Гурав дахь зүйл энэ харьцангуй ерөнхий асуулт юм. Хууль дээр 8.2.7-д ингэсэн байгаа олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого гэдэг дээр үндэсний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахыг эрмэлз гэсэн байгаа юм. Энэтэй холбоотой хүүхдийн нэвтрүүлгийн сая хасчихсан гэсэн ийм мэдээлэл байна. Энэ яагаад?

Хоёр дахь зүйл бол 2023 оны 6 сараас эхлээд Тува хэл дээр, Буриад хэл дээр, Казак хэл дээр энэ мэдээ явдаг байсан. Энийгээ хасчихсан. Энэ 12 оноос эхэлсэн уг нь үйл ажиллагаа л даа. Тэгээд энэ яагаад ингээд хасчхав. Энийг та бүхэн минь тайлбарлаад өгөөч. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүний асуултад ажлын хэсгийн 5 номерын микрофон Монсор дарга хариулъя.

Н.Монсор: Баярлалаа. МҮОНРТ-ийн хууль маань өөрөө 2005 онд батлагдсан. Энэ 20 жилийн хугацаанд гол сорилтуудын нэг маань орлого тал харагдсан. Яагаад гэхлээр түрүүн орлогын эх үүсвэр маань өөрөө их тодорхойгүй байхлаар байгууллага дээр жишээлэх юм бол ийм тогтворгүй байдал үүсэх эрсдэл аягүй их гардаг. Жишээлэх юм бол түрүүн хэллээ. Бид нар орлого тал дээр түрүүн гаргасан төсвөөс жишээлэх юм манай маш 40-өөс бараг 50 хувь нь шахуу төсвөөс хараатай байдаг. Гэтэл тухайн төсөвт бид нар урсгал зардалдаа тухайн жилийнхээ төсөвт энэ чинь 7 сараас эхлээд суулгуулах гээд явсаар байгаад л одоо өнөөдөр хүртэл ингээд явж байгаа. Энэ маань өөрөө эргүүлээд хэрвээ бид нар энэчээнээс ингээд тодорхой хэмжээний таналт хийлгэчих юм бол энэ яг цэвэр байгууллагыг ийм эрсдэлд оруулах ийм аюултай байдаг. Тэгэхлээр бид нарын Үндэсний зөвлөл дээр бид нарын ярьдаг энэ дотоод гэдэг юм асуудлуудаас гадна гэх юм бол энэ гол бодлогын асуудал энэ орлогын тогтвортой байдал. Энийг хураамжийн орлогыг түрүүн хэлсэн. Анх 98 онд энэ хураамжийн орлого тухайн үедээ 1 доллар байхаар дүйцүүлж тогтоосон.

Гэтэл өнөөдөр энэ маань хөдөлмөрийн хөлсний хэмжээ маань 66 дахин нэмэгдчихсэн байхад МҮОНРТ-ийн Монгол Улсын энэ соёлын өвийг тээгч ийм байгууллагуудынх нь нэг нь яг хэвээрээ явж байгаа. Ийм эрсдэл байгаа. Орон тооны мэргэжлийн шийдвэр түрүүн хэлсэн энэ юуны манайх энэ хажуудаа энэ зөвлөл байгуулагдаагүй.

3 дахь асуулт нь гэх юм бол хуулийн 8.2.7 энэ Ерөнхий захиралд илүү их хандах байх. Яагаад гэхлээр бид нарын хувьд төсвөө баталж үйл ажиллагааг нь батлахдаа энэ 5 суваг болон энэ 3 радиогийнхаа сувгаар олон улсад мэдээ дамжуулах тэр үндсэн хэлүүдээрээ яаж байгаа ийж байгаа гэдгийг нь баталж өгөөд явуулдаг. Тэрийг Гэрэл захирал хариулах байх.

Ц.Сандаг-Очир: Нэмж ажлын хэсгийн 6 номерын микрофо. Гэрэл захирал асуултад хариулья.

Г.Гэрэл: Үндэсний олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлогын 8.2.7-нд үндэсний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн бүлэг давхаргын болон олон нийтийн одоо мэдэх эрхийг хамгаалах, тэнцвэртэй хангахыг одоо эрмэлзэж ажиллах гэж энэ хөтөлбөрийн бодлогын хэсэг дээр заасан. Хүүхдийн нэвтрүүлгийн хувь хэмжээ огт буураагүй. Ер нь энийг байнгын тогтмол авч явдаг. Хүүхдийн нэвтрүүлгийг тогтмол хийдэг эфирийнхээ сүлжээнд байлгадаг, байнгын редакцын үйл ажиллагаа эрхэлдэг бараг цөөхөн хэдэн редакциятай байгууллагын нэг бол Үндэсний олон нийтийн радио, телевиз. Радио дээр мөн хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, контент, үлгэр цуврал ийм хичээлүүдийг бас энэ уран сайхны нэвтрүүлгүүд би хийж байна. Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг мэдээ, мэдээллийн цагийг бид нар улам өргөжүүлж байгаа. Та бас.../минут дуусав./

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд хариулчихъя. 1 минут. 6 номер.

Г.Гэрэл: Үүнтэй холбогдуулаад бүтцийн өөрчлөлтөөр гэр бүл сувгийг бас үүсгэсэн. Энэ гэр бүл суваг дээр хүүхэд хөгжил, гэр бүлийн ш мэдлэг, мэдээлэл, гэр бүлд зориулсан хөтөлбөрийг илүү түгээх үүднээс 5 дугаар суваг маань байгуулагдсан.

Тува хэл болон үндэсний цөөнхөд зориулсан энэ нэвтрүүлэг яагаад алга болсон бэ гэхээр нөгөө мэдээ, мэдээллийн хувьд жоохон дутмагшилтай байсан юм болов уу. Тухайн үед Үндэсний зөвлөлөөс бүтцийн өөрчлөлт орсон. Тэгээд энэ үндэсний цөөнхөд зориулсан 2 дугаар сувгийг Монголын мэдээ суваг болгож өөрчилсөн учраас чиглэл нь өөрчлөгдсөн. Гэхдээ энэ үндэсний цөөнхөд зориулсан мэдээ, мэдээллийг бид нар байнга, хэдийгээр Тува хэлээр биш ч гэсэн энэ мэдээ, мэдээллийг түлхүү өгч бас хөтөлбөрийнхөө бодлого шингээж ажиллаж байгаа.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүн тодруулъя. 1 минут.

С.Зулпхар: Яг одоо иймэрхүү бидэнд харилцан мэдээлэл солилцох нь их чухал байгаа юм. Тэгэхлээр сая Ганбаатар гишүүн ч гэсэн хэлж байна. Энэ Эн Эйч Ки-тэй ижилхэн, Би Би Си-тэй, адилхан Орти, Хятадын Си Си Тв гэдэг ч юм уу, Солонгын Кэй Би Эйс тэгээд Туркийн Тирти-тэй адилхан байх ёстой гэж. Ийм л зорилгоор энэ хууль анх гарсан. Энэ арилжааны одоо телевиз биш олон нийтийн радио, телевиз учраас бидэнд үндэсний хэмжээний тодорхой хөтөлбөрийн бодлого байх ёстой. Тэрийгээ авч явна гэдэг үүднээс. Тэгэхээр энэ рүү чиглэсэн байдлаар та сая зарим сорилтыг хэлж байна. Тэгэхээр тэр хураамжийг нэмэгдүүлэх нь чухал юм уу, эс үгүй бол өөр жишээ нь арга хэрэгсэл байна уу гэдэг энэ дээр та бүхэн бас тодорхой бас санал хэлэх ёстой. Хураамжаар хийнэ гэвэл жишээ нь л хэрэг байх. Гэтэл өөр жишээ нь гаднын улс орнуудын бас тийм арга, туршлага юу байна? Төрөөс шууд татаас өгөх ёстой юм уу? Яагаад гэвэл энэ чинь төрөөс дэмжлэг үзүүлэх ёстой томоохон одоо хэвлэл мэдээллийн байгууллага гэдгийг бид ойлгочихсон байгаа шүү дээ. Тэгэхээр энэ үүднээс нь та бүхэн ямар саналтай байна гэдэг ийм асуулт байна. Дарга би 1 минут нэмээд.

Ц.Сандаг-Очир: 1 минут Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Тэр саяын тэр цөөнхийн мэдэх эрхтэй холбоотой асуудал. Энэ анх хуулиа боловсруулахдаа ч гэсэн тэрийг мэдэж хийсэн байхгүй юу даа бид. Ер нь Их Хурлаас цаашдаа батлагдах хуулиуд дээр ч гэсэн хүний эрхийн мэдрэмжтэй байх, эс үгүй бол хүний эрхийн мэдрэмж нь жишээ нь алдагдсан хууль байх юм бол тэрийг янзална гээд ийм стратегиа тодорхойлчихсон юм. Энэ стратегийг хэрэгжүүлж байгаа нь Үндэсний зөвлөл өөрөө хуулийн хэрэгжилтийг.

Тэгэхлээр саяын өөр суваг болгочихсон ч гэсэн энэ байхгүй болчихсон гэдэг бол энэ хангалтгүй тайлбар байна. Энэ бидэнд сайн туршлага байна шүү дээ. Өнгөрсөн 12 оноос хойш явж байсан 3 хэл дээрх мэдээ шүү дээ. Зөвхөн мэдээ дамжуулдаг цөөнхийн жишээ нь эх хэл дээрээ мэдээлэл авах, төрийнхөө мэдээллийг сонсох энэ эрхийг үндэснийхээ олон нийтийн радио, телевизээр дамжуулж өгч байгаа хэлбэр байхгүй юу. Энийгээ та бүхэн Үндэснийхээ зөвлөл дээр ахиж яримаар байна. Тэгж байж одоо энэ Гэрэл жишээ нь захирлыг, Гэрэл захиралтай радио, телевизийн энэ үйл ажиллагааг дэмжиж өгөх ёстой байх гэсэн ийм бодолтой байна. Энэ бидний хувьд том үлгэр жишээ болох одоо бас ийм зүйл шүү дээ бусад улс орнуудад гэсэн үг. Сайн туршлага болж байгаа учраас сайн туршлагаа цааш нь аваад яваач ээ гэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Санал. Эхнийх нь асуулт. 5 номерын микрофон. Монсор дарга.

Н.Монсор: Зулпхар гишүүнд баярлалаа. Түрүүны таны хэлсэнчлэн өөр тактикууд бас байж болно. Энэ орлогын талаар бид нар ийм илүү аюулгүй болгох жишээлэх юм энэ Туркийн Терти гээд телевиз жишээлэх юм бол яг хүүхдийнхээ сувагтаа тусгайд нь төсөв гаргаж санхүүжүүлдэг юм байна лээ төсөвтөө суулгаж. Бид нар энэ хувилбаруудыг одоогоор судалж байгаа. Ер нь манай ингээд хураамжийг хэрвээ ингээд аваад үзэх юм бол энэ олон улстай ингээд харьцуулаад үзэхэд бол хамгийн жишээ нь гэхэд Би Би Си буюу Их Британийн Үндэсний олон нийтийн телевизтэй нь ингээд харьцуулахад манайх 58.5 дахин бага хураамж авдаг байх жишээтэй. Энэ Эйч Кэй-ийг бодоход 25.5 дахин, Германы Цэ Ди Эф болон Ар Ди гээд сувгийг харьцуулахад 69 дахин, Италийн Рай гээд олон нийт.../минут дуусав./

Ц.Сандаг-Очир: Нэмээд 1 минут гүйцээгээд хариулчихъя. 5 номерын микрофон.

Н.Монсор: Италийн Рай телевизтэй харьцуулахад 28 дахин. Солонгосынхтой харьцуулахад Ки Би Эс-тэй харьцуулахад 6 дахин, Эс Жи Ар Жи Швейцартай харьцуулахад 111 дахин, Австрийн Ое Эф-тэй харьцуулахад 94 дахин, Шведийн Эс Ви Ти-тэй харьцуулахад 44 дахин, Финландын Вая Эл-тэй харьцуулахад 44 дахин ийм бага байгаа. Гэтэл өнөөдөр бид нар энэ даяаршиж байгаа нийгэмд энэ мэдээлэл гэдэг маань өөрөө маш чухал. МҮОНРТ яг энэ Монгол Улсын Мон 3.5 сая хүн иргэнд хүргэж байгаа энэ мэдээлэл, боловсрол энэ соёлд өөрийн гэсэн тодорхой байр суурьтай. Гэтэл яг энэ өнөөдрийн байгаа энэ хураамж дээр ийм харьцангуй ийм хүрэлцээ муутай. Тэгээд ингээд эрсдэл үүсгэх ийм байдалтай байдаг.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Би асуулт гэхээсээ ер илүү бараг үг хэлчих байх даа л. МҮОНРТ гэдэг маань одоо бид хуулиа одоо яаралтай шинэчлэх хэрэгцээ

шаардлага байна гэдгийг харж байгаа. Тэгээд шийдвэрлэх хэрэгтэй 1 асуудал байгаа нь олон нийтийнх юм уу, эс үгүй бол төрийнх юм уу. State control юм шиг л одоо ойлголтыг олон нийтэд өгч байгаа. Яагаад гэхлээр олон нийт ер нь төр л өөрийнхөө хүссэн мэдээллүүдээ явуулаад байгаа юм биш үү гэдэг л ийм хардалтыг байнга бий болгодог шүү дээ. Тэгж ч ажиллаж байгаа явдлууд гардаг. Тэгээд энэ юунаас улбаатай байна вэ гэхлээр энэ үндэсний зөвлөлийн гишүүдээ хүртэл хэрхэн яаж сонгон шалгаруулж байгаа вэ гэдэгтэй ч гэсэн шууд холбоотой. Ер нь үндэсний телевизэд байгаа хүмүүсийг гэдэг юм уу яг шийдвэр гаргаж байгаа хүмүүсийг бүгдэнг нь яг судлаад үзэх юм бол цаанаа л бас төрийн юу гэдэг юм улс төрийн хамааралтай, улс төрийн нөлөөлөлтэй ийм хүмүүс цөөнгүй байдаг. Энэ бол нууц биш.

Тэгэхээр яг энэ төрийн өөрийн оролцоог нь хэрхэн яаж бууруулах вэ гэдэг дээр л бид нар яг одоо санаа зовох ёстой. Үүн дээр бас өөрчлөлтүүдийг зайлшгүй одоо хийх одоо шаардлагатай байна гэж үзэж байна. Хэдийгээр хураамжаа нэмэгдүүлэх нь одоо зүйтэй гэж үзэж байгаа боловчиг яг иргэд өнөөдөр итгэж хураамж нэмэгдүүлэхийг одоо зөвшөөрөх үү үгүй юу гэдэг нь том асуудал. Тэгэхээр эргээд иргэдийнхээ итгэл үнэмшлийг авахын тулд бид өнөөдөр яг үнэхээрийн олон нийтийн одоо телевиз мөн шүү гэдгийг контент, хандлага, үйл ажиллагаагаараа харуулах ёстой. Гэтэл яг одоогоор тийм биш байна гэдгийг бүгд хүлээн зөвшөөрөх байх гэж бодож байна. Арилжааны телевизээс их ялгаагүй байгаад байгаа. Ер нь Үндэсний телевизийн Цагийн хүрдийг л бараг үздэг, өөр бусад асуудлуудыг үздэггүй иргэд маш олон байгаа байх гэж би дүгнэдэг. Тэгэхээр энэ дээр яаралтай нэгдүгээрт хуулийг шинэчлэх шаардлагатай байна. Нөгөө талдаа яг энэ Үндэсний зөвлөлийн гишүүдийг хэрхэн яаж сонгон шалгаруулж байгаа вэ, хэн санал болгож байгаа вэ гэдгийг бас нэлээд нухацтай ярилцахгүй бол дандаа ардаа улс төрийн нөлөөлөлтэй хүмүүс байгаа гэдгийг бид нар хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэгээд үүн дээр ч гэсэн дүгнэлтээ хийж үндэсний телевизийг иргэд олон нийтийнхээ итгэлийг хүлээсэн яг үнэхээрийн л иргэддээ хүрч ажилласан ийм телевиз болгохын төлөө бид шинэчлэлтийг яаралтай зайлшгүй хийх ёстой гэдэг ийм саналтай байна.

Ц.Сандаг-Очир: Үг хэлчихлээ Ариунзаяа гишүүн. Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: 2005 онд батлагдсан хуульд 10 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Хамгийн сүүлийнх нь 2024 он. Тэгээд нэмэлт, өөрчлөлт орох болгондоо сайжирсан уу гэвэл бас сайжраагүй. Тэгээд энэ хууль ингээд 2 жилд 1 удаа өөрчлөгддөг гэсэн үг л дээ. 650 хүний орон тоотой, 26 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардалтай, үндсэн хөрөнгө нь 16 тэрбум юм байна. Тэгээд энэ аудитын дүгнэлтээс шүү. Одоо тэгээд энэ Монголын үндэсний телевизийн олон нийтийн радио, телевизийн энэ хөрөнгө 16 тэрбум 900 сая төгрөгөөр үнэлэгдэж байгаа юм уу гэдэг асуулт байгаа юм. Энэ чинь маш том объект шүү дээ. Тэгээд кино фондоо 4.2 тэрбумаар үнэлсэн юм байна. Энийг яаж үнэлсэн юм бэ гэдэг асуулт байна. Түүх музейн дурсгалт зүйл нь 24 сая төгрөг юм байна. Би энэнээс харьцангуй их болов уу гэж бодож байна эхнийх нь. Бас ийм логикийн зөрчил байгаад байгаа юм аа. Үндэсний телевиз үздэггүй хүмүүс хураамж төлөх нь зөв үү гэдэг асуудал.

Тийм болохоор би Үндэсний телевизээс хэдэн асуулт асууж байгаа нь эхний ээлжид зах зээлийн судалгаа буюу хийсэн судалгаан дээр Улаанбаатар хот 2 ангилаад, түүний дотор мэдээ, мэдээлэл, технологитой холбоотой нэвтрүүлэг, хүүхэд залуучуудын нэвтрүүлэг гээд үзэлтээрээ Монголын үндэсний телевиз,

бусад арилжааны телевизтэй рейтингийн хувьд хэдэд байдаг юм бэ? Ийм судалгаа байгаа юу? Хамгийн сүүлийнхээр ингэж асуухгүй бол бид нар чинь одоо 2 жилийн өмнөх үйл ажиллагааны тайлан хэлэлцээд байна шүү дээ. Энэ чинь одоо өнгөрчихсөн гэсэн үг байхгүй юу. 2 жилийн өмнө. Энэ одоо ямар шалтгаантайг нь мэдэхгүй байна.

Хоёрдугаарт, улс төрийн нөлөөлөл хэр байдаг вэ гэж. 15 Үндэсний зөвлөлийн гишүүнтэй. Миний буруу санаагүй бол энэ хуульд яг энэ томилгооны өөрчлөлт ороогүй Улсын Их Хурлаас, Засгийн газраас, Ерөнхийлөгч ч бас. Тэгээд дандаа улс төрийн субъектүүдээс томилж байгаа учраас энд улс төрийн нөлөөлөл, хараат бус байдал байхгүй байна гэж ойлголт энгийн логикоор байхгүй. Тэгэхээр та нарт ажил хүнд хийхэд улс төрийн нөлөөлөл, дарамт шахалт нь хэр байдаг вэ гэдэг.

Гуравдугаарт, энэ маркетингийн зардлын 2 хувь гэдгийг нэгэнт энэ хуулийг хөндөх асуудал яригдаж байгаа бол энийг нь ихэсгэх хэрэгтэй. 2 хувийг нь ядаж 5 хувь болгоход маркетингийн орлого чинь нэмэгдэнэ. Тэгэхгүй 2 хувь гээд блоклоод хаячихаар тэнд яг ний нуугүй хэлэхэд бизнесийн байгууллагуудад өрсөлдөөн явдаг ар, өврийн хаалга явдаг. Тэгэхээр яг энэ зах зээлийн судалгаатай холбоотой юмнууд.

Дөрөв дэх асуулт нь орон тоогоо батлахдаа та хэд Үндэсний зөвлөлийнхөө гишүүдийг оруулаад баталчихсан. Гэтэл энэ чинь өөрөө хуульд заачихсан Үндэсний зөвлөлийн хорооны гишүүд байгаа шүү дээ. Хуульд заачихсан юмыг та нар орон тоогоор батална гэдэг энэ бас логикийн асуудал, зөрчил үүсэж байна. Тэгээд сүүлийн 4 жилд Монголын Үндэсний олон нийтийн телевиз хэчнээн төгрөгөөр тоног төхөөрөмжөө шинэчилсэн юм, үйл ажиллагааны шинэчлэлт нь хэр явсан юм, техник технологийн хоцрогдол нь хэр байгаа юм гээд. Яагаад ингээд асуугаад байна. Хувийн хөрөнгө хөрөнгө оруулаад сайн телевизэд хийж болоод байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Шууд тодруулах уу дараа нь уу? Монсор дарга ажлын хэсгийн 5 номерын микрофон. Шижир гишүүний асуултад хариулъя.

Н.Монсор: Шижир гишүүн хэллээ. Энэ хөрөнгөтэй холбоотой МҮОНРТ-ийн хөрөнгийн дахин үнэлгээн дээр одоо би анх ирсэн өдрөөсөө хойш нэлээн их ярьж байгаа. Энэ дахин үнэлгээ хийх энэ процесс манай Монголд энэ харьцангуй өөрөө их шинэ юм байна лээ. Яагаад гэхлээр та түрүүн хэллээ энэ урлагийн тэр тайз засал ч гэдэг юм уу ингээд маш олон юмнууд байдаг. Энэ дээр бид нар анхаарах ёстой. Үзэлтийн судалгаа байгаа юу гээд. Миний Монголд уг нь үзэлтийн судалгааг аягүй нарийн гаргадаг байсан энэ олон улсын Максимагийнх нь тийм арга байсан юм байна лээ. Тэгээд тэр маань өөрөө компани маань дампуурчихсан. Би тэгээд 23 онд анх ирээд 23 оны намар судалгаа нэг хийлгэж байсан. Тэр маань тэгэхдээ маш цөөнхөөс цөөхөн хүнээс хийж байсан судалгаа. 22 онд Эм Эм Си Ти-гийн хийсэн тийм судалгаа байдаг юм байна лээ. Тэрийг бас энэ гишүүддээ бид нар дараа нь бас хүргүүлье. Тэр дээр та, гишүүд маань бас яг хэлж байна. Зарим контентууд маань нэлээн их үзэлттэй байдаг, тодорхой контентууд нь жоохон үзэлт нь бага байдаг юм байна лээ.

Улс төрийн нөлөөлөл байгаа юу гэж асуулаа. Би зөвхөн өөрийнхөө өмнөөс хариулна. Над дээр ямар нэгэн байдлаар одоо улс төрийн дарамт шахалт ч гэдэг юм уу тийм юм ирж байгаагүй. 2 хувийн энэ орлого талаар зөвшөөрөгдсөн уран

бүтээлийн 2 хувь нэмэх асуудал энэ яах вэ болно. Бид нар энэ дотроо ярьж байгаад энэ хуулийн саналыг, өөрсдийнх нь саналыг явуулж болох байх. Тэгэхдээ Эн Эйч Кэй-ийг ч гэдэг юм уу энэ олон улсад харж байхлаар энэ 2 янз байгаад байдаг юм байна лээ.

Яагаад гэхлээр энэ нөгөө тухайн улс үндэстнийхээ нөгөө өв соёлыг тээж байгаа, үр хүүхдүүдээ хүмүүжүүлж байгаа гэдэг утгаараа бүүр огт сурталчилгаа явуулах ёсгүй гэж бас үздэг улсууд байдаг юм байна лээ. Зарим нь тэр нь түрүүн хэлсэн хураамж нь маш тодорхой. Тэгээд төсвийг нь батлахдаа төсөвт нь уялдуулаад хураамжаа Үндэсний Зөвлөл нь өөрөө баталж явж байдаг ч гэдэг юм уу ингээд өөрчилж байдаг. Хамгийн сүүлд гэхэд бид нар Эн Эйч Кэй-ийн түншүүдтэйгээ уулзаж байхад Эн Эйч Кэй хураамжаа нэмэх биш 1 удаа багасгасан байдаг юм байна лээ. Яагаад гэхлээр техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлээ хийж сүүлийн 10 жил хийгээд одоо бид нар ингээд тодорхой хэмжээний 2 жилийн пауз авах учраас энийгээ жоохон буулгаж байгаа гэж мэдээлэл өгч байсан.

Хуульд заасан орон тоон дээр бид нар энийг эргэж харах нь зүйтэй байх. Сүүлийн 4 жилийн тоног төхөөрөмжтэй холбоотой шинэчлэл дээр яг одоо шууд ингээд 4 жилийн хугацаанд тэдэн төгрөгийн юу гээд хэлэхэд болохгүй байна. Энэ Гэрэл захирал хариулах уу?

Ц.Сандаг-Очир: Ахиад асуулт дутуу байна гээд байна Шижир гишүүн. Тэр тэнд, тэр юу руу л сууна ажлын хэсгийн энэ гол руу орж сууна тэгж байж хариулна. Наад микрофонууд чинь ажиллахгүй. Хэн билээ? Үндэсний зөвлөлийн гишүүн Алтанцэцэг гишүүн. Ажлын хэсгийн 1 номерын микрофон. Ажлын хэсгийн 1 номерын микрофон .

С.Алтанцэцэг: Сайн байцгаана уу? Миний нэр Алтанцэцэг Үндэсний зөвлөлийн өргөдлийг шалгах хорооны даргаар ажилладаг. Манай өргөдлийг шалгах хороонд Үндэсний зөвлөлийн нэр дээр ирсэн өргөдөл, гомдлыг шалгаж, Үндэсний зөвлөлийн хуралд оруулж танилцуулахаас шийдвэр гаргахаас гадна судалгаа бас хийх үүрэгтэй байдаг юм. Үүнтэй холбогдуулаад МҮОНРТ-ийн үндэсний хэмжээний нэр нөлөө, иргэдийн итгэл хүлээсэн байдал гэж үндэсний хэмжээнд ийм рандом судалгаа хийсэн байгаа 22 онд энэ Максима судалгааны байгууллагатай хамтраад. Тэгээд Шижир гишүүний асуултад нэмж хариулахад техник технологиор бусад телевизүүдийн хаана явдаг юм бэ гэж манайхыг асуусан. Зүгээр яг бусад телевиз, арилжааны телевизүүдтэй харьцуулж энэ удаад бид нар судалгаа хийгээгүй. Хийхдээ ямар төрлийн дэлгэц төхөөрөмжөөр Монголын

Ц.Сандаг-Очир: 1 минут нэмээд. Тодорхой хариулахгүй бол минутдаа багтахгүй байна шүү дээ та. Ажлын хэсгийн 1 номерын микрофон.

С.Алтанцэцэг: Ямар төрлийн дэлгэц төхөөрөмжөөр хүлээж авдаг вэ гэж орон нутагт болон Улаанбаатар хотод бид нар харьцуулсан судалгаа хийсэн байгаа. Тэгэхээр гэрийн зурагтаар манай нэвтрүүлгийг 51.7 хувьтай үздэг юм билээ. Шугамын радиогоор 1.5, машины фмээр 6.7, машины дэлгэцээр 2.5, гар утсаар 7.4, компьютероор 2.2, i pad-аар 05, бусад хэрэглэлээр гээд ингээд гарч байгаа юм. Орон нутагт ойролцоо, ер нь ойролцоо ингэж гарч байгаа юм. Гэрийн зурагтаар 53, шугамын радиогоор 2 хувь гээд. Ер нь Үндэсний олон нийтийн радио, телевиз үндэсний хэмжээний нэр нөлөө иргэдийн итгэл хүлээсэн байдал энэ нь ер нь хэр зэрэг хүлээн зөвшөөрч байна гэдэг судалгааг үндэстэн даяар

рандом байдлаар хийсэн ийм судалгааг Төрийн байгуулалтын байнгын хороонд бид нар явуулсан байгаа хийсэн судалгааныхаа ажлыг явуулсан байгаа. Энэнээс би сая Шижир гишүүний асуултад манай хийсэн.../минут дуусав./

Ц.Сандаг-Очир: Нэмж хариулах хүн байна уу Шижир гишүүний асуултад? Шижир гишүүн асуултаа тодруулъя.

Ө.Шижир: Зүгээр ингэж асуугаад байгаа юм. Зүгээр жишээ аваад хэлчихье. Намайг хүүхэд байхад Үндэсний телевизийн Цагийн хүрд гэдэг бол мэдээ, мэдээллийн гол эх сурвалж буюу тэрийг үнэн гэж итгэдэг байсан байхгүй юу. Үнэн гэж итгэдэг байсан. Одоо энэ өөрөө итгэх итгэлийн одоо хувь нь хэд байгаа юм бэ гэдгийг нь та нар үзэлтээс асуугаад байгаа юм. Юнивишнтэй ч юм уу, эсвэл Скаймедиатай яриад тэдний технологиор судалгаа хийж болно шүү дээ энэ чинь технологи хөгжчихсөн. Тэнд судалгаа хийж байгаа юм. Бүүр энгийнээр асуугаад байгаа бол Монгол коммент, Цагийн хүрд 2-ын үзэлтийн харьцаа хэд байгаа юм бэ гэж асуугаад байгаа байхгүй юу. Аль нь илүү итгээд байгаа юм бэ гэж асуугаад байгаа юм. Миний бүүр маш энгийн буулгаж өгвөл танд болж байгаа асуултыг. Байж байгаарай. Тэгээд миний санал тэртээ тэргүй үндэсний телевиз үздэг үү хэдэн хувь байгаа юм энэ тоо байна уу гээд байгаа юм. Тоо байгаа бол 30 хувь юм уу 40 хувь тоо байж л байгаа шүү дээ. 3 хувь ч юм уу, 5 хувь мэдэхгүй. Тийм бол энэ хүмүүс 1000 төгрөгийг нь авахаа болиод маркетингийн 2 хувиа 5 хувь болгочиход тэр орлогоо зөрөөд олчих юм биш үү л гээд байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Шижир гишүүний асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 6 номерын микрофон. Гэрэл захирал.

Г.Гэрэл: Шижир гишүүний асуултад хариулъя. Жишээлбэл Монгол коммент, Цагийн хүрд 2-ын алийг нь одоо үздэг бол оо гээд та одоо бүр их тийм хялбаржуулсан байдлаар асууж байна. Тэгэхдээ та судалгаа асуулаа. Тэгэхээр яг энэ тухайн контентыг хэдэн хүн нь үзэж байгаа юм бэ, өнөөдөр энэ телевизээр үзэж байгаа, зааланд байгаа 100 хүний 20 хувь нь, 20 хүн нь Цагийн хүрд үзэж байна. 10 хүн нь Монгол коммент үзэж байна гэдэг энэ судалгаа бол Монгол Улс даяар байхгүй байгаад байгаа юм. Ер нь судалгааг сүүлийн үед яаж гаргаж байна вэ гэхээр хандалтын судалгаагаар л одоо гаргаж байгаа. Мэдээж энэ техник, технологийн хувьд шинэчлэгдэж байж судалгааных нь байгууллага нь өөрөө энэ технологио нэвтрүүлж байж бид нар энэ телевизийн түвшинд энийг мэдэх боломжтой. Зүгээр хүмүүсийн хандалт ямар байгаа юм бэ гэдэг юм уу, сошиал дээр танайхыг юу гэж үзэж байгаа юм бэ гэдэг юм уу ингээд асуувал одоо бас судалгааны үр дүн, эсвэл одоо энэ хариулт өөр одоо болох байх. Сүүлийн үеийн маркетингтай тодорхой үйл ажиллагаа явуулдаг.../минут дуусав./

Ц.Сандаг-Очир: 1 минут. Шижир гишүүн 1 минут тодруулъя.

Ө.Шижир: Яах вэ технологийн шийдэл чинь хийгдчихсэн байна л гээд байна л даа. Би одоо би түрүүн жишээ явлаа шүү дээ. Одоо Юнивишн, Скаймедиа гээд одоо гуравласан үйлчилгээ үзүүлдэг энэ компаниуд аль аль телевизийн ямар хандалтаа гаргаж ирдэг. Үгүй ээ тийм биз. Тэгэхээр нэгэнт танай суваг зарим орон нутгууд дээр эдгээрийн одоо дэд бүтцийг ашиглаж гарч байгаа бол зарим тохиолдолд. Энэ судалгаа хийгд хийгдэх боломж байгаа шүү дээ л гээд байхгүй юу. Тэгээд 23 оноос хойш гэхэд чинь 4 жилийн хугацаанд үзэлтийнхээ болон нэвтрүүлгийнхээ цар хүрээний хүүхэд, залуучуудын хүрээний энэ судалгаа хийгээгүй болохоор та нар бизнес төлөвлөлтөө яаж хийх юм бэ л гэдэг энэ бас

энгийн логик байхгүй юу. Энэ чинь одоо нэг талаасаа орлого олж байгаа байгууллага шүү дээ. Тэгэхээр одоо зүгээр дахиад асууя 2 хувиа 5-8 хувь болгоод эфирийн цагийнх нь сурталчилгааны цаг болж нэмэгдүүлээд, телевиз үздэггүй хүмүүсээс 1000 төгрөгийг нь авахаа больчихвол хөрөнгийн ялгаа, мөнгөн урсгалын ялгаа чинь хэр өөрчлөгдөх юм? Нэмэгдэх юм уу хасагдах юм уу гэдэг л юм асуугаад байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Монсор дарга. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Н.Монсор: Шижир гишүүний асуултад хариулахад түрүүн миний яг эргүүлээд л анх ярьсан асуудал байгаад байгаа юм. Яг энэ судалгаа энийг ингээд өргөн хүрээтэй хийлгээ гэхлээр манай дээр яг үнэндээ төсвийн асуудал яригдаад эхэлдэг. Яагаад гэхлээр бид нар жилдээ байгаа төсвөө хүргэх гэж энэ хүмүүсийн цалин тавиад НДШ тэгээд энэ ЭМД-ыг нь төлөөд ингээд яаж үймээн самуунгүй байлгах вэ яаж энэ тогтчихсон байгаа өнөөдрийн контентоо яаж тасралтгүй явуулах вэ энэ хооронд энэ цахим шилжилтийг бид нар бас яаж хийх вэ гэдэг энэ ажил маань явагдаж байгаа. Яриагүй биш бид нар энэ судалгааг ярьж байгаа. Гол нь энэ төсвийн асуудал байгаад байгаа юм. Яг өнөөдөр 2 хувиас 7 хувь болгоод тэгээд яг үзэхгүй байгаа хэсгийг нь ингээд хасвал хэд болох вэ гэхлээр бид нар яг тэр тоо байхгүй.

Ц.Сандаг-Очир: Бас хангалтгүй л хариулж байна шүү. Номин гишүүн асуултаа асууя.

Ч.Номин: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Үндэсний телевиз бол үндэсний ижилсэлт маш чухал. Одоо бид бүхний өв соёлоо үр хойчдоо түгээх, Монгол хэлийг, хэл бичгийг таниулж түгээж явах, цаашлаад одоо Монгол Улсын тусгаар тогтнолд маш чухал. Тийм учраас бид нар Үндэсний телевизийг тогтмол хураамжтай, дээрээс нь төсвөөс татаастай авч явах ёстой. Гэхдээ тэглээ гээд нөгөө талдаа бас анхаарах зүйлүүд байгаа. Би үндэсний телевизийн татаас, дээрээс нь энэ хураамжуудыг нэмэгдүүлэх ёстой гэж боддог хүний нэг. Өнөөдөр бид нар энэ үндэсний телевизийн тайланг үзэж байна л даа. Ойролцоогоор 23 тэрбум төгрөгийн зардалтай юм байна. Энэ дотор их сонин зүйл би бас уншчихаад энийг асууя гэж бодоод байгаа юм. Борлуулсан ажил, үйлчилгээний өртөг гээд гаргаад ирж байгаа юм.

Тэгээд энд 3 зүйлээс бүрддэг гэж байгаа юм. Зардлыг радио, телевизийн үйлчилгээний өртөг, төлбөртэй үйлчилгээний өртөг 2 дахь нь, 3 дахь нь төсөл, хөтөлбөрийн өртөг ийм 3 зүйлээс бүрдүүлдэг гээд ингээд гаргаад ирж байгаа юм. Би бодох нь ээ энэ бодвол контентынх нь зардал юм болов уу гэж харж байна. Ингээд 13 орчим тэрбум төгрөг нь болохоор цалиндаа явчихдаг юм байна. Би юу гэж харж байна вэ гэхээр нэгдүгээрт бүтээмжээ нэмэгдүүлэх ёстой болов уу гэж харж байгаа. Өнөөдрийн тайлан, 2 тайлан хоёулаа үйл ажиллагааны тайлан байлаа. Юун түрүүнд тайлагналаа зөв хийхээс ажил чинь эхэлнэ. Гэрэл захирлын тайлан бол газрын даргын тайлан байна. Үндэсний зөвлөлийн тайлан бол гүйцэтгэх захирлын тайлан байна. Өнөөдөр бид нар үр дүн, дүгнэлт ярьж байх ёстой. Юун түрүүнд та бүхэн суурь судалгаагаа хийгээд, зөв төлөвлөөд, энэ төлөвлөгөөгөө хэрэгжилтийг нь хийгээд энэ хэлээд байгаа рейтингийн судалгаан дээрээ хяналтаа хийж яваад ингээд зөв тайлагнаад явбал системээ зөв болгох нь хамгийн түрүүний зүйл байна.

Өнөөдөр тэр та бүхний тавьсан тайлангаас яг ямар дүгнэлт гаргах вэ гэхэд маш учир дутагдалтай зүйл гарч ирж байна. Уг нь энэ дээр хүний нөөц чинь ямар байгаа юм, үйл ажиллагаа чинь ямар байгаа юм, ямар контент хийгээд ямар рейтингтэй явж байгаа юм. Үүнээсээ дамжуулаад ямар санхүүгийн үр өгөөжтэй ашигтай байгаа юм. Дээрээс нь хүн бүрээс авч байгаа хураамждаа бид нар ямар хэмжээний үнэ цэнийг иргэдэд бүтээж байгаа юм бэ гэдэг ийм тайлан тавих юм бол энэ дээр бид нар эргүүлээд та бүхний төсвийг нэмэгдүүлэх ёстой гэдэг юм яриад сууж байх ёстой байтал өнөөдөр та бүхний тайлан процессын тайлан орж ирсэн учраас бүтээмжтэй ч биш, ойлгомжтой ч биш ийм тайлан орж ирээд бид нар өөр зүйл яригдаж байна.

Тэгэхээр цаашдаа та бүхэн ажилдаа би ямар зүйлийг анхаарч яваач ээ гэж хэлэх гээд байна вэ гэхээр суурь судалгаагаа заавал хий. Иргэд юу үзмээр байгаа юм, ямар байдлаар өв соёлыг хармаар байгаа юм, үзмээр байгаа юм, сонсмоор байгаа юм. Ямар контентоор дамжуулж бид нар Монгол хэлийг хүүхдүүдэд таниулбал хэрэгтэй юм гээд ийм суурь судалгаан дээр суурилсан төлөвлөлттэй, үүнийгээ харьцуулсан буцаагаад.../минут дуусав./

Ц.Сандаг-Очир: Номин гишүүн тодруулга 1 минут.

Ч.Номин: Тэгээд энэ дээрээ суурилсан хэрэгжилтийн тайлангаа рейтингийнхээ судалгаатай харьцуулаад ингээд сегментээ таниулаад явах юм бол контентын бүтцээ танилцуулахдаа энэ контентоор дамжуулж энэ сегментэд бид нар ийм хэмжээний үр дүн, үр өгөөжийг өгсөн юм гээд тайлангаа тайлагнаад явбал эргээд та бүхэнд энэ төсвөө нэмэгдүүлэх, дээрээс нь иргэд та бүхний хийж байгаа ажлыг ойлгоход илүү болов уу гэж бодож байна. Тэгээд миний асуулт түрүүний хэлсэн энэ яагаад энэ борлуулсан үйл ажиллагааны өртөг гэж ийм 3 хуваагаад байгаа юм бэ? Энийгээ танилцуулаад өгөөч. Энэ чинь арилжааны байгууллагатай адилхан юм орж ирж байна л даа.

Ц.Сандаг-Очир: Номин гишүүний асуултад хэн хариулах вэ? Хэн хариулах вэ? Гараа өргөөрэй. Санхүүгийн албаны дарга. Ажлын хэсгийн 8 номерын микрофон хариулъя.

А.Цэвэлсүрэн: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ болохоор Номин гишүүний асуугаад байгаа асуулт болохоор нөгөө улсын стандартыг нь олон улсын стандартыг нь санхүүгийн тайланг нь бүтцийн тоо асуугаад байгаа юм шиг байна. Энэ дээр болохоор яг стандарт дээр борлуулсан бүтээгдэхүүний өртөг гэж ойлголт байдаг. Энийг болохоор программчлагдаад хуваагаад гаргасан тоог асуугаад байгаа юм болов уу гэж би бодож байна. Хуваарилсан тоог асууж байна гэж ойлгож байна.

Ц.Сандаг-Очир: Номин гишүүн тодруулга 1 минут. Номин гишүүн.

Ч.Номин: Би энийг та бүхний контент үйлдвэрлэлийн зардал байна гэж харж байна. Ийм 3 байдлаар хуваарилдаг бололтой юмаа л гэж харж байна. Яагаад гэхээр тийм таны хэлж байгаа борлуулсан бүтээгдэхүүний өртөг нийлбэрээрээ 19 тэрбум болж гарч ирж байна. Тэгэхээр нэг ёсондоо та нар 23 тэрбум төгрөгийн зардлын чинь 19 тэрбум нь миний ойлгож байгаагаар борлуулсан бүтээгдэхүүний өртөг буюу контент үйлдвэрлэж байгаа зардал чинь юм болов уу гэж хараад байгаа юм. Тэгэхээр нэгэнт ийм хэмжээний өртгийг бид нар одоо соён гэгээрүүлэх ажилдаа зарцуулж байгаа учраас буцаагаад ямар

өгөөжтэй байгаа юм бэ гэдгээ л та нар харуулах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол та нар ямар ч өгөөж таниулахгүйгээр, үр дүн таниулахгүйгээр тайлан бичиж орж ирээд энэ тайлан чинь зүгээр л үйл ажиллагааны гүйцэтгэх захирлын түвшинд газрын дарга нарын тавьдаг тайлан оруулж ирж байгаа байхгүй юу. Үр өгөөжөө таниулж чадах юм бол та бүхний төсвийг нэмэгдүүлэх, цаашлаад илүү та бүхэнд боломж олдох боломж байна гэдгийг хэлэх гээд байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Хариулт хэрэгтэй юу? Хэрлэн гишүүн асуултаа асууя.

Б.Хэрлэн: Бүгдээрэнд нь энэ өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр таны энэ ирүүлсэн материалууд дотроос ингээд харж байхад Үндэсний зөвлөлийн гишүүд хуралд суугаад, хуралд суусангаараа цалингаа аваад явдаг гэсэн. Тэгэхээр сая ирц нь хүрэхгүй болохоор тайлангаа хэлэлцэж амжаагүй гэж хэлж байгаагийн учир нь яг юу юм бол? Та нар чинь их хатуу бүртгэлтэй байдаг юм байна лээ шүү дээ. Аудитаар үзээд танайхныг хуралд суугаагүй байхад нь цалинг нь өгсөн байна гээд бүүр ингээд ийм дүгнэлт гарчихсан байгаад байдаг. Тэгэхээр яагаад танай гишүүд чинь хуралдаа суудаггүй юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, менежментийн хувьд танайх Үндэсний зөвлөл чинь Үндэсний зөвлөлийн 1 гишүүн нь Хяналтын зөвлөлийнхөө дарга нь байгаад явчихдаг. Тэгээд Хяналтын зөвлөл хажуудаа Өргөдлийн шалгалтын хороо гээд тэгээд дээр нь дотоод аудит гээд ингээд танайх чинь хянах, шалгах талын хэд хэдэн ийм давхардсан ийм зохион байгуулалтын нэгжүүд байна шүү дээ. Тэгэхээр одоо миний ингээд сая сонсож байхад тэр Өргөдлийн шалгалтын хороог чинь Хяналтын зөвлөл рүүгээ нийлүүлчхэж болдоггүй байсан юм уу? Ажил үүргийнхээ давхардлыг багасгах үүднээсээ, орон тоогоо хэмнэх үүднээсээ гэсэн ийм бодол надад төрж байна.

Гуравдугаарт нь ерөнхийдөө МҮОНРТ гэдэг бол радио нь болоод ирэхээр чинь 91 жилийн түүхтэй, телевиз нь одоо 58 жилийн түүхтэй маш их бас туршлагатай ийм байгууллага. Барилга юу гэдэг юм материаллаг бааз суурийн хувьд, хүн хүчний хувьд танайх хамгийн хүчирхэг ийм байгууллага. Танай урианд чинь болоод ирэхээ үндэсний ухамсар, үндэсний оюун санааны түүчээлэгч байх гэсэн тийм том уриатай танай байгууллага ийм байгаа.

Тэгэхээр одоо би юу асуух гээд байна вэ гэхээр яг үнэхээрийн үндэсний, оюун санаа үндэсний ухамсрыг одоо ингээд ийм түүчээлэх ийм байгууллагынхаа яг энэ нийгэмд гүйцэтгэх үүргээ гүйцэтгэе гэвэл та нар өнөөдөр сая Шижир гишүүний асуултад ч байна, Номин гишүүний асуултад ч байна. Одоо тэр нөгөө программ хөтөлбөрүүд дээрээ та нар дүн шинжилгээ хийсэн үү? Бусад телевизүүдтэй харьцуулахад хандалт нь аль одоо хөтөлбөрийнх нь арай өндөр байгаад байгаа юм. Яагаад доогуур байгаад байгаа юм, танайх үнэхээр яг үндэсний тэр оюун санаа, ухамсрын түйчээлэгч байх үүргээ үнэхээрийн тэр нэвтрүүлгүүд чинь биелүүлж чадаж байгаа юм уу үгүй юм уу гэдэг дээр та нар дүн шинжилгээ хийж үзсэн үү гэж асуумаар байна.

Ц.Сандаг-Очир: Хэрлэн гишүүний асуултад хэн хариулах вэ? Монсор дарга. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Н.Монсор: Үндэсний зөвлөлийн энэ хуралтай холбоотой асуултыг асуулаа Хэрлэн гишүүн. Хурал бол би түрүүн хэлсэн хурлаа Үндэсний зөвлөлийн дарга болон хэрвээ шаардлагатай үед 5 гишүүн санал гаргаснаар хурлыг хуралддаг.

Тэгээд хурлыг байгаа үедээ хурлын дарга даргалаад, байхгүй үед хурлын даргын томилсон хүн даргалдаг. Хурлын хувьд бид нар цалин авдаггүй. Бид нар урамшуулал гэж хэлдэг. Энэ урамшууллыг авдаг. Энийг бид нар зохицуулахдаа урамшууллын журам гэж дотроо байдаг. Тэгээд манайд ямар асуудал үүсдэг вэ гэхлээр одоо энэ ирцтэй холбоотой Үндэсний зөвлөлийн даргын хувьд жишээлэх юм бол тэр хэн нэгний урамшууллыг хасах ч байдаг юм уу, эс үгүй бол нэмэх ч байдаг юм уу надад тийм эрх байхгүй. Тэгээд ийм асуудал байгаа.

Гишүүддээ байнгын хурлаа битгий таслаарай, хуралдаа байнга ирээрэй, битгий хурлаа бойкотлоорой ч гэдэг юм уу ийм уриалгыг байнгын хүргэж явдаг.

Үндэсний зөвлөлийн, Хяналтын зөвлөл бол түрүүн та хэллээ Өргөдлийг шалгах хороод Хяналтын зөвлөл хоёрыг ингээд нийлүүлэх боломжтой юу гэвэл энэ өөрөө хууль дээрээ манайх заачихсан байгаа болохоор одоогоороо бид нар ингээд дураараа энийг нийлүүлэх боломжгүй. Дээрээс нь энэ 2-ын маань яах вэ функц нь 2 жоохон өөр.

Оюун санааны түүчээлэх байгууллага, энэ ретикийн дүн шинжилгээ энэ хөтөлбөрийн бодлоготой холбоотой асуулаа. Бид нарын хувьд түрүүн хэлсэн нэг том асуудал энэ төсвийн асуудал байдаг. Энэ анх 98 онд тогтоосон энэ хураамж одоо ингээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ингээд 66 дахин нэмэгдчихээд байхад энэ маань ерөөсөө нэмэгдээгүй. Тэгээд хүмүүс маш их олон талаас нь хардаг юм байна лээ. Ийм их олон хүн ажиллаад бүтээмж нь бага байна гэдэг. Би бол анх өөрөө энд томилогдож ирээд эхний 3 сар нөхцөл байдлынх нь анализыг нэлээн хийсэн. Ингээд харж байхад хувийн телевизтэй харьцуулахад контент үйлдвэрлэл ч гэдэг юм уу, брокастинг ч гэдэг юм уу, ... ч гэдэг юм уу бидний, бид бүхний яриад байгаа энэ гар утасны энэ контентыг түгээх асуудал дээр нэлээн их асуудлууд байсан.

24 онд түрүүн яах вэ дурдагдаагүй МҮОНРТ гар утас руу нэлээн их том дижитал шилжилтийг хийчихсэн. Тэгээд үнэ төлбөргүйгээр 5 суваг болон энэ радио нь гар утсан дээр тогтмол явдаг болчихсон байгаад байгаа. Энэ нь эргүүлээд түрүүн Шижир гишүүний асуулт дээр бас ингээд нийлүүлээд хариулахад хэрвээ магадгүй бид нар энэ өөрсдийн сан хөмрөг ч гэдэг юм уу энэ архивд байгаа контентоо магадгүй энэ аппликэйшнээрээ зараад төлбөртэй өгөх юм бол бас ийм орлогын бас боломж байх бололцоотой болно.

Нөгөө талаараа өргөн нэвтрүүлгээр явж байгаа контентыг бид нар тоолоход маш хэцүү. Тэгээд энийг уг нь нэлээн нарийн тоолдог байсан байгууллага нь нээлттэй тоолж, нээлттэй сервис үзүүлдэг байгууллага тэр Максима нь дампуураад алга болчихсон юм байна лээ.

Скайтел, Юнител, Юнивишн гээд энэ хувийн компаниудаас бид нар тийм шууд нээлттэй мэдээлэл авах эрх байхгүй. Энэ өөрөө эргүүлээд нөгөө хувь хүний нууцтай холбоотой бас ийм хуулийн заалтууд бас байдаг юм шиг байна лээ. Тэгээд бид нар хандаж үзсэн.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Энэ Гэрэл захирлаас асууя. Ер нь телевиз маань нэлээн тийм өр төлбөртэй гэж түрүү түрүү жилд ингээд сонсогддог байсан хуримтлагдсан.

Тэгээд энэ дээр та бүхэн ямар нэгэн арга хэмжээ авч байгаа юу, ахиц дэвшил гаргаж байгаа юу гэдэг 1 асуулт.

Ер нь бид нар энэ өв соёл, түүхийн чиглэлээр одоо манайд тун цөөхөн телевиз энэ нэвтрүүлэг хийж, контент бэлдэж ,ард түмнийг соён гэгээрүүлэх чиглэлээр явж байгаагийн нэг ууган бөгөөд хамгийн архив сайтай, хамгийн агуулга сайтай нь манай үндэсний телевиз шүү дээ. Одоо сүүлдээ бидний энэ эх орон, тусгаар тогтнол, өв соёлтой холбоотой зүйлүүд дээр залуу үе нь мэдэхгүй байх, хууччуул зарим нь үгүйсгэх ийм хандлага хүртэл гарч байна л даа.

Гэтэл бид чинь арвин баялаг түүхтэй, бахархах олон бахархалтай, олон баатруудтай ийм л ард түмэн л дээ. Тэгэхээр энэ чиглэлийн одоо контент юмнууд үргэлжлээд явж байгаад баяртай байна. Нэн ялангуяа бас би өөрөө радио сонирхогч хүний хувьд дэлхий даяар энэ Монголын радиог сонсоод хүлээгээд сонсоод байдаг радио сонирхогчид байдгийг мэддэгийн хувьд, нэн ялангуяа энэ Монгол үндэстэн, ахмад настан, радио сонирхогч хүмүүс бас олноороо байдаг ийм энэ асуудлыг ойлгодгийн хувьд Хөх тэнгэр радиог бас сэргээж цацаж эхэлсэнд бас та бүхэнд бас талархал илэрхийлье. Энэ мундаг сайн ажил болсон шүү.

Ер нь үеийн үед энэ Үндэсний телевизийн радио, телевизийг ажилчид олонтой, бүтээмж багатай гэдэг ч юм уу ийм шүүмжлэл гардаг байсан. Тэгэхээр миний 2 дахь асуулт бол энэ ажилтан, албан хаагчдынхаа одоо энэ ажлын байрны давхцал, хөдөлмөрийн бүтээмж, ажлын байрны зураг авалт, чиг үүргийн давхцалыг нь арилгах зорилгоор ер нь хийсэн ажлууд байгаа юу? Энэний үр дүн гарсан зүйлүүд байгаа юу гэсэн ийм 2 үндсэн асуулт асууя. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Гэрэл захирал хариулъя. Ажлын ажлын хэсгийн 6 номерын микрофон. Баярлалаа.

Г.Гэрэл: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр одоо өнөөдрийн энэ тайлан дээр гарч байгаачлан 23 оны төгсгөл 24 оны энэ үйл ажиллагаан дээр бид нар 5.8-ын хасахтай баланстай, өр авлагатай ийм байгууллагыг хүлээж авсан. Улсын төсвийн дэмжлэг байгаагүй бол энийг бас давж тулахад хэцүү байсан. Мөн дотооддоо зохион байгуулсан олон ажлууд байгаа. Нэгдүгээрт, өөрийнхөө үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх, реклам зар сурталчилгаа, хамтын ажиллагааныхаа үйл ажиллагааг сайжруулах, бүтэц орон тоогоо оновчтой болгох.

Өнөөдрийн байдлаар МҮОНРТ-д 562 хүн яг одоо ажиллаж байна. 560"улаа бүхэл бүтэн энэ системийг авч явж байгаа радио, телевизийн энэ одоо байгууллагын хувьд, мөн эх орон даяар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын хувьд одоо бол оновчтой болж байгаа гэж би бодож байна.

Өмнө нь энэ өр, авлагууд яагаад үүссэн бэ гэвэл нэгдүгээрт энэ орлогоо олоогүй, шийдээгүй байж байж энэ цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотой шийдвэр гарснаас болж энэ авлага нэмэгдэж, гэнэтийн ийм асуудалд орсон. Тийм учраас төс төсвийн орлогын дэмжлэгээр бид нар энэ асуудлыг даван гарсан. Тэгэхдээ дахиж одоо ийм нөхцөл байдалд хүрэхгүйн тулд нэгдүгээрт бүтэц, орон тоогоо оновчтой болгох, хөтөлбөрийн бодлогоо шинэчилж сайжруулах, мөн орлого олох, буцаагаад тэрийгээ хөтөлбөртөө шингээдэг байх энэ механизмуудыг бүгдийг нь жижиг гэлтгүй авч хэрэгжүүлсэн. Мөн манай байгууллагын хувьд хэдийгээр 562 хүн, 512 хүн ажиллаж байна. 50 хүн бол жирэмсний амралт, чөлөөтэй байна.

Тэгэхээр 510 хүний энэ үйл ажиллагаа маань өөрөө тогтмол явах үүднээс, мөн хөдөлмөрийн энэ цалингийн систем байнга уг нь өсөн нэмэгдэж байх ийм шаардлагатай. Гэхдээ одоо бас энэ төсвийн янз бүрийн асуудлуудаас болж бид нар энэ цалин, орлогыг нэмэгдүүлж чадахгүй байгаа. Түрүүн энэ 40 хувь буурсан нь ямар учиртай юм бэ гэж асуусан. Цалин бол буураагүй. Тэгэхдээ хангалттай хэмжээнд нэмэх боломж бас үүсэхгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бид нар илүү их салбар болгон дээр жижиг гэлтгүй бүх үйл ажиллагаан дээр менежмент хэрэгжүүлж байж орлогоо нэмэгдүүлэх, мөн энэ хуулиа зөрчихгүйгээр хөтөлбөрийн бодлогодоо таарсан шинэчлэлийг зохион байгуулах ийм шаардлагатай гэж бодож байна.

Таны хэлсэн энэ архив болон үндэсний энэ агууламжтай энэ контентуудыг сэргээн бий болгох, архивыг олон нийтэд таниулах, эргээн сэргээх, буцаагаад дижитал хэлбэрт оруулж энэ радиогийн 90 жил, телевизийн 60 гаруй жилийн энэ хальсан болон дууны архивыг сэргээх ажлыг бид нар бас энэ 24 оноос хэрэгжүүлж байна. Ингээд гаднын Тика гээд байгууллагын тусламжтайгаар бид нар энэ 12 сарын эхээр тоног төхөөрөмжөө хүлээж авч дижиталжуулах энэ ажлыг эхэлнэ. Гэрээ байгуулагдаад тоног төхөөрөмж наашаа ирэхэд бэлэн болж байгаа гэх мэтчилэн бид нар бас энэ орлогын эх үүсвэрийг гадаад хамтын ажиллагаа болон энэ өөрсдийнхөө боломжид тулгуурлаж шинэчлэх, сайжруулах, орлогоо нэмэгдүүлэх тэгэхдээ хуулийн хүрээнд байх ийм аргыг эрэлхийлж ажиллаж байна.

Энэ рейтингийн судалгааг түрүүн бас гишүүд маань ярилаа. Үнэхээр үнэн. Тэгэхээр бид нар энэ одоо яг хаана байгаа юм, ямар контент нь илүү сайн байгаа юм, аль нь ил одоо илүү анхаарал хандуулж ёс ажиллах ёстой юм бэ гэдгийг олон улсын судалгааны байгууллагаар тогтоолгох шаардлагатай байна.

Ялангуяа Монголд энэ тухай тодорхой мэдээллийг гаргаж өгөх судалгаа одоо хийгдэхгүй байгаа учраас бид нар энэ олон улсад хандаж, тухайн контент болгоны үр өгөөжийг сайжруулах мөн таны түрүүний хэлсэнчлэн энэ архивд байгаа Монголчуудын түүх, соёлыг хамгаалсан энэ контентуудыг ребрендинг хийж дахин сэргээх ийм үйл ажиллагаанууд 26 оноос шилжиж орно.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу болсон уу? Би тэнд 2 номерын микрофон нэмэлт хариулт юм уу? Хэн билээ? Албан тушаалаа хэлээд ажлын хэсгийн 2 номерын микрофон.

Н.Онон: Сайн байцгаана уу? Үндэсний зөвлөлийн гишүүн Онон гэж хүн байна. Би түрүүний Энхтуяа гишүүний асуултад хариульъя. Сая ингээд тайлан сонслоо. Сая 2, 3 цаг ингээд сонслоо. Зүгээр 24 оны тайланг Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдтэйгээ цуг Үндэсний зөвлөлийн гишүүд сонсож байгаад их баяртай байна. Бид нараар ерөөсөө хэлэлцүүлээгүй. Монсор одоо худлаа ярихаа больцгооё. Ирц хүрээгүй биш, хүрсэн. Үндэсний зөвлөл үндсэндээ дампуурчихсан шүү. 25 онд тайлангаа та яаж хэлэлцэх гэж байгаа юм би ойлгохгүй байна. 24 онд эрх биш 13 удаа хуралдсан болсон.

Ц.Сандаг-Очир: Онон зөвлөлийн гишүүн ээ яг Алтангэрэл гишүүний асуусан асуулт.

Н.Онон: Алтангэрэл гишүүний асуултад биш, би Энхтуяа гишүүний асуултад нөхөж хариулах гэсэн юм.

Ц.Сандаг-Очир: Тийм дэг байхгүй. Та би тэгвэл танаас асууж болно. Би бас хувь гишүүнийхээ хувьд асуулт асууна. Би энэ Үндэсний зөвлөлийн 24 оны үйл ажиллагааны тайланд хийсэн дүн шинжилгээг ингээд харж байгаа юм. Тэгээд энэ дүн шинжилгээнд нэгд Үндэсний зөвлөлийн шийдвэрийн талаарх мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна. Шилэн дансны мэдээллийг цахим хуудсандаа 22 оноос хойш байршуулаагүй байна. 6 сараас хойш байршуулаагүй байна гэж байгаа юм. Энэ нөгөө энэ олон нийтийн радио, телевизийн ил тод нээлттэй байх байдал яаж байна вэ? Энэ дээр хариулж өгөөч.

Мөн энэ дүн шинжилгээн дээр зар сурталчилгаанаас 2024 онд 4.2 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Гэхдээ гэвч Үндэсний аудитын газрын тайланд 9.8 тэрбумыг олох боломжийг алдсан байна гэж аудит дүгнэсэн байна. 9.8 тэрбумыг. Энийг юу гэж үзэж байгаа вэ хоёрт асууя.

Гуравд, нийт ажилчдын хамгийн бага болоод хамгийн өндөр цалингийн хэмжээ хэд байна, дундаж цалин хэдийг авч байна одоо? Энэ 500 гаруй, 600 орчим одоо ажилчид маань. Би буруу санаагүй бол 2, 3 жилийн өмнө 22, 23 оны үед бас л баахан ажил бөөн юм болоод л манай Их Хурлын гишүүдээс Оюунчимэг гишүүд рүү очоод л хурал зөвлөгөөн хийж байсан. Тэндээс харахад бас их улс төрждөг газар юм байна гэдэг нь харагдахаар байсан. Тэгээд сая одоо Монсор даргын тайланд бас мэр сэр хариултад дурдагдаад л байна.

Тэгээд тэндээс юу байна гэхээр энэ Үндэсний зөвлөл нь бас цаг хугацаандаа хурлуудаа хийхгүй байгаа асуудлууд яригдаад байна. Тайланд тэр Хяналтын зөвлөлийн тайланд харагдаад тусаад байна. Энэ төсөв, төлөвлөгөөг цаг хугацаанд нь хэлэлцэж баталдаггүй, үйл ажиллагааны тайланг цаг хугацаанд нь хэлэлцэж баталдаггүй, хойшлуулдаг гэдэг энэ асуудлууд чинь яагаад цаг хугацаандаа хийгддэггүй юм бэ гэдгийг. Тэр сая түрүүн Шижир гишүүний асуултад юу гээд хариулчхав. Удирдах зөвлөлийн гишүүдийг үндсэн бүтэц орон тооныхоо 500, 600 орчим ажилчдынхаа орон тоонд оруулаад баталчихсан гэх юм. Ийм юм байж болдог юм уу? Энийг санхүүгийн бүхэл бүтэн газар нягтлангууд нь юу гэж үзээд энийг нь батлаад явж байдаг юм? Үндэсний зөвлөл чинь компаниар бол ТУЗ-ийн гишүүд шүү дээ. ТУЗ-ийн гишүүдийг компанийнхаа ажилчдын орон тоонд батлаад явж байдаг ийм байгууллага байдаг юм уу, болдог юм уу. Энэ ямар хуультай зөрчилдөх вэ? Энэнд түрүүнд тодорхой хариулт өгөөгүй.

20 жил болж байгаа Үндэсний олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага юу байна гэж та бүхэн үзэж байна, үзэж байна? Ийм боловсруулсан хуулийн төсөл байна уу? Та бүхэн 2 жилийн өмнө шахуу 24 оны 4, 5 сард Засгийн газарт үнэ тарифаа нэмэгдүүлэх ийм санал өгсөн гэсэн. Энэ өнөөдрийг болтол асуудал нь шийдэгдээгүй явж байна. Энд яагаад ингээд шийдэгдээгүй юм бол, юу гэж та бүхэн тухайн үед хариултыг нь өгсөн юм бол? Энэ дээр. Танай үйл ажиллагааны санхүү, өр төлбөрийг нэлээн барагдуулсан харагдаж байна. Барагдуулахаас өөр аргагүй юм байна.

Яагаад гэхээр 24 онд Сангийн сайд та нар төсвөөс 5.6 тэрбум төгрөгийн татвар авдаг байсан, татаас авдаг байсан бол энийг чинь 2 дахин нэмэгдүүлээд 10 тэрбум төгрөгийн татаас өгдөг болчихсон байхгүй юу. Ингээд алдагдлыг чинь ерөөсөө ингээд шууд дарчихсан. Энэ тэрнээс үйл ажиллагааны сайн гэдэг юм уу, орлого одоо сайжраад зардлаа бууруулаад ингээд алдагдал буурчихсан юм ерөөсөө харагдахгүй. Та нарт өгдөг татаасыг 5 тэрбумыг чинь 10 тэрбум болгож

өгдөг болчихсон. Ингээд алдагдлыг чинь шууд дарчихсан ийм л одоо санхүүгийн тайлангаас чинь тоо харагдаж байна.

Тэгээд өнөөдөр бид нар ингээд хараат бус бие даасан байдалтай байх ёстой. Гэтэл та бүхний төсөв, санхүү одоо улсын төсөв хэлэлцээд байж байхад манай Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудалд ерөөсөө орж ирэхгүй байгаа байхгүй юу. Манай гишүүд мэдэхгүй. Сангийн сайдын багцад явж байгаа. Та бүхний төсөв. Тэгээд нөгөө хараат бус байдал чинь Засгийн газраас, Сангийн яамнаас хараатай байгаа юм биш биз дээ, төсөв, санхүүгээрээ барьцаалагдчихсан байгаа юм биш биз дээ гэдэг ийм хар төрхөөр байгаа байхгүй юу.

Тэгээд би Байнгын хорооны гишүүдээ цаашдаа тайланг нь болохоор бид нар хэлэлцэх үүрэгтэй. Санхүүг нь болохоор Сангийн сайд нэмж, хасахыг нь мэддэг. Ийм одоо зарчимгүй юм байж болох юм уу, үгүй юү? Цаашдаа энийг одоо хааш нь одоо оруулах юм ч гэдэг юм уу гэх мэтчилэн. Ингээд олон асуудлууд одоо бас Үндэсний олон нийтийн радио, телевизтэй холбоотой асуудлууд байна. Би та бүхний тан манай хамт олны хийж байгаа олон ажлуудыг үгүйсгээгүй ээ. Олон сайн ажлуудыг хийж байгаа.

Гэхдээ бас та бүхний үйл ажиллагаанд Үндэсний зөвлөлийг чинь одоо энэ 3 субъектээс Ерөнхийлөгч, Их Хурал, Засгийн газраас томилогдож байгаа энэ 15 хүний бүрэлдэхүүнтэй энд нөхдүүд чинь ер нь яг Үндэсний зөвлөлийнхөө гишүүний үүрэгт ажлыг хийж байна уу үгүй юү гэдэг асуудал их эргэлзээ төрүүлж байна шүү. Хараат бус байх байдал чинь нэлээд одоо энэ дээр асуудал дагуулж байна шүү. Бие биеийнхээ одоо санал болгосон субьектийнхээ эрх ашгийг хамгаалдаг юм биш биз дээ. Хараат бус байдлаар ажиллаж чадахгүй тэнд очиж улс төржүүлээд байдаг юм биш биз дээ гэдэг ийм асуудлууд бас одоо танай байгууллагуудад бас нэлээн тавигдаж харагдахаар байна шүү. Тэгээд миний энэ одоо 5, 6 асуултад Монсор дарга, Гэрэл захирал, санхүүгийн албаныхан эд нар гээд хариулж өгөөч.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Н.Монсор: Үндэсний зөвлөлөөс та сая асуулаа. Энэ нөгөө хураамжтай холбоотой, төсөвтэй холбоотой асуудлыг энэ маань өөрөө эргүүлээд та сая хэллээ энэ Сангийн яамны багц дээр ордог. Энэ маань өөрөө эргүүлээд бид нар энэ байгууллага дээр эрсдэл үүсгэх маш их тийм өндөр боломжтой. 2023 онд 23 оны төгсгөлөөр манайх бүүр ажилчид маань одоо бас тухайн үед нэлээн ийм хүндрэлтэй байдалд орж байсан. Нэмэлт шаардлагын хувьд гэвэл хуульд Үндэсний зөвлөлөөрөө бид нар бас хэлэлцээд энийгээ саналаа явуулах ёстой байх. Яагаад гэхлээр би одоо Үндэсний зөвлөлийнхөө гишүүдийн өмнөөс ярьж болохгүй байх.

9.8 тэрбум төгрөг олж болох байсан гэдгийг одоо манай энэ санхүүгийнхэн эргүүлэн хариулах байх. Шилэн данс хөтлөхийг бас гүйцэтгэх удирдлага маань хариулах байх. Үндэсний Зөвлөлийн хурлын шийдвэрийг бид нар өөрийн Эм Эн Би цэг мн гэдэг сайт дээрээ хурал болсны дараа байнга оруулж байдаг. Энийг манай нарийн бичиг хариуцаж ажилладаг. Энэ тухайн үед нь бид нар оруулж явж байгаа.

Ц.Сандаг-Очир: Үгүй ээ та чинь одоо тэгээд Үндэсний Зөвлөлийн дарга танд ер нь хариулах, мэдэх юм байгаа юм уу? Бүгдийг нь бусад руугаа ингээд хийгээд, тэнд хариулна, энд хариулна гээд. Уг нь та одоо ингээд өмнөөс нь энэ бүх

тайланг нь сонсчихсон, алдаа дутагдлыг нь олоод харчихсан, захирал маань одоо шилэн дансанд материалаа тавихгүй байгаа. Бид нар энийг нь авч хэлэлцээд ингээд одоо энэ алдааг зас засруулсан залруулсан гээд. Энэ чинь хуультай шүү дээ гээд яриад байж байтал одоо манай гүйцэтгэх захирал мэднэ ээ гээд ингээд хариулаад байж байх юм. Энийгээ та нар Үндэсний зөвлөл дээр ярьдаггүй юм уу?

Ц.Сандаг-Очир: Гэрэл захирал хариулъя.

Г.Гэрэл: Би энэ үйл ажиллагаатай холбоотой өөрийн хариуцаж байгаа хэсгээс хариулъя. Манай цалингийн дундаж 1 сая 513 мянган төгрөг байна. Хамгийн бага цалинтай хүн бол 1.2 сая төгрөг цалинтай. Их гайгүй өндөр сар тутам өндөр гүйцэтгэлтэй байгаа ажилчдын цалин 1 сая 950 мянган төгрөг байна. Байгууллага дотроо би контрактын гэрээгээр ажилладаг ийм гүйцэтгэх захирал байгаа юм. Тэгээд мэдээж одоо би энэ орон тоондоо орж байгаа учраас хамгийн өндөр цалинтай нь би л байх шиг байна.

Нийт ажилчдын дундаж цалин 1 сая 513 мянган төгрөг байна. Эндээсээ нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар гээд ингээд тодорхой татваруудыг төлөөд ингээд гар дээр 1 сая 100, 200 мянган төгрөг орчмыг авч ажилладаг ийм цалин багатай уран бүтээлчид байдаг.

Шилэн дансны хуулийг 22 он хүртэл тогтмол одоо хийгээгүй байна гэж Үндэсний аудитын тайлан дээр гарсан юм.

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд хариулъя.

Г.Гэрэл: 22 оноос хойш тогтмол энэ Шилэн дансныхаа тухай хуулийн дагуу гүйлгээ, үйл баримтуудыг бүгдийг нь одоо нийтэлж ажиллаж байгаа. Шилэн данс руу орохоор одоо манай байгууллагын үйл ажиллагааны бүхий л тайлан гарна.

Ц.Сандаг-Очир: Онон гишүүн. Үндэсний зөвлөлийн гишүүн Онон гишүүн хариулъя. Ажлын хэсгийн 2 номерын микрофон.

Н.Онон: Сайн байцгаана уу? Сандаг-Очир гишүүний асуултад хариулахад тэр Үндэсний зөвлөлийн орон тоог бүтэц өнөө Үндэсний олон нийтийн радио, телевизийн бүтцэд багтаачихсан талаар асууж байна. Энэ чинь аргагүй шүү дээ. Одоо миний мэдэхийн 25 оны төсөв, төлөвлөгөөг одоо Үндэсний хяналтын зөвлөлөөр оруулаагүйгээр Үндэсний зөвлөлөөр танилцуулсан. Тэгэхдээ Хяналтын зөвлөлийн мэргэжлийн улсуудаар оруулаагүйгээр, хянуулаагүйгээр шууд баталчихсан байхгүй юу. Зүгээр л танилцъя гэж оруулж ирээд л танилцангуутаа шууд энийг баталчихъя гээд л. Миний бие бол энэ хуралд чинь суухгүй ээ гээд л орхиж явсан протокол дээр байгаа. Гэх мэтчилэн одоо ингээд ийм дампуурчихсан дампуурсан асар бий шүү. Одоо энд яах вэ Монсор дарга гоё гоё юм яриад одоо 2, 3 цаг гишүүдийн ажлыг ч гэсэн бараад яах вэ дээ. Яривал их юм байгаа даа 1 минутад багтахгүй байх.

Ц.Сандаг-Очир: Гишүүд МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, мэдээлэлтэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Ганбаатар гишүүнээр, Хэрлэн гишүүнээр тасаллаа, Алтангэрэл гишүүнээр тасаллаа.

Ганбаатар гишүүн үгээ хэлье.

А.Ганбаатар: Одоо зүгээр санал хэлье гэж байгаа юм. Монголын Үндэсний радио, телевизийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг сайжруулах, ажилчдын нийгмийн асуудлыг шийдэх, улс төрөөс ангид байх энэ зарчмыг одоо хангах үүднээс 2 шатын ажил хийх ёстой юм байна гэж харж байна. Хамгийн түрүүнд энэ Нийтийн сонсголын тухай хуулийн 8.5-д, Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 119.1.2 дээр, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29.20.2.2 гээд өөрөөр хэлбэл олон нийтийн радио, телевизийн талаар хуулийн хэрэгжилт хэрхэн байгаа талаар үнэлгээ хийх ийм сонсгол хийвэл яасан юм бэ гэсэн. Энэ сонсгол гээд одоо сүүлийн үед сонсгол хийгээд байхаар байцаадаг, шалгадаг, хамаг юмыг нь ухдаг, төнхдөг гэж ойлгоод байх шиг байна. Миний одоо энэ санаачлаад хийх гэж байгаа санал оруулж байгаа энэ сонсгол бол энэ олон нийтийн радио, телевизийг хуулийнх нь хүрээнд яаж ажиллуулбал одоо зүйтэй байх вэ гэдэг хуулийн төслүүдийг хэлэлцэх, тэр бэрхшээлүүдийг нь шийдэх, дэмжлэг тусалцааг үзүүлэх энэ чиглэлд хийе гэсэн ийм бодолтой байна. Нэгд нь.

Хоёрт нь энэ сонсголын дараа судалгаа хийх хэрэгтэй. Судалгаагүй ажиллаад байгаа харагдаж байгаа. Гэхдээ олон нийтийн телевизийн заавал контентоороо тэргүүлээд байх шаардлагагүй шүү дээ. Тийм чиг үүрэг байхгүй. Энэ соёлын өвийг тээгч, Монгол Улсын одоо үндэсний дархлааг хамгаалж байгаа Үндэсний радио, телевиз.

Тэгэхээр контент бүр чинь одоо номер нэгээр явах арилжааны телевиз шиг ийм мөнгөний хойноос явах онцын шаардлага байхгүй. Хуулийн төсөлтэй хэдүүлээ улсын төсвөөс яг хэдэн төгрөг авах юм, тэр төсвөөрөө хэдэн хүн цалинжуулах юм, байр савандаа хэчнээн түрээсийн студиуд ажиллуулах юм, тэр контентоо яаж цааш нь борлуулж, тэд нараасаа яаж бас санхүүгийн эх үүсвэр гаргах юм, тэр юу авч байгаа шүү дээ, хураамж. Хураамж авна гэдэг чинь нөгөө сэтгэл ханамжтай контент дээр хүн мөнгө төлдөг. Тэгэхээр тэрийг бас судлах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл арилжааны телевизийн контент 10, 20 мянгаар үзээд байгаа шүү дээ. Ай Пи телевизүүдийн контентыг.

Тэгэхээр Монгол телевизийн контентуудыг хүн үзэж байгаа Монголын мэдээ Монгол телевиз ард иргэд хэрэгтэй гэж үзвэл тэр хураамжийг бодлогын чанартай санал асуулгаар дэмжүүлээ д ингээд нэмүүлж болно шүү дээ хуулийн төсөл оруулаад. Тэгээд яг энэ төсөвт гарч ирж байгаа тэр мөнгөндөө таарсан энэ бодлогыг олон нийтийн радио, телевизийнхээ үүрэг чиглэлээ тодорхой болгоод ингээд хийчихэд зүгээр л баланс хийгээд л явахад болох ийм байгууллага байхгүй юу. Ашиг орлого олохын төлөө, тэнд улс төржихийн төлөө ямар ч шаардлага байхгүй. Тэгээд 15 гишүүнийг сонгож байгаа энэ сонгон шалгаруулалтыг бас шүүмжлэлтэй хандаад байгаа юм. Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газраас хүн санал болгохоор тэр хүмүүс нь хувь улс төртэйгөө холбогдоод, тухайлбал Эм Эн-ийн мэдээ, мэдээлэл гарах, орох хүний хувьд листийг нь хүртэл гаргаж байгаа гэсэн ийм юм байдаг.

Тэгэхээр энэнээс ангид байхын тулд хуульдаа шалгаруулах процессыг нь яаж хийж өгөх юм бэ. Магадгүй олон нийт хувьцаа авдаг public limited ийм телевиз байж болохгүй юм уу гэдэг хүртэл саналыг ярилцмаар байгаа байхгүй юу. Тэгэхээр

одоо миний хэлэх гээд байгаа зүйл мэргэжил нэгт нөхдөдөө уриалахад олон нийтийн радио, телевиз бол дотроо маргаантай, улс төртэй байгаа шалтгааныг нь олоод хуулиараа сайжруулъя. Бусдаар энд орж ирчхээд би шүүмжлээд байх онцын шаардлага байхгүй. Бүгдээрээ нэг нэгний төлөө явж байгаа бол энэ сонсголыг хамтдаа хийгээд хэн нэгнийг муутгах юу гэдэг юм хэрэг төвөг татах асуудлаар биш, олон нийтийн радио, телевизийг сайжруулах, түрүүн дурдаад байсан гаднын олон нийтийн радио телевизийн зэрэг зиндаанд хүргэх, Монголын дархлаа бас ийм телевиз байгуулахын төлөө энэ сонсголыг хийе ээ гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Шижир гишүүн саналаа хэлье.

Ө.Шижир: Үндэсний телевизийн түүхэн ач холбогдол, түүхэн үүрэг түүнд хадгалагдаж байгаа архивын баримт материалуудыг хэн ч үгүйсгээгүй. Тийм ч учраас Үндэсний телевиз өөрөө байх ёстой гэдэг зарчмын байр суурьтай байгаа. Гэхдээ ямар хэлбэрээр байх вэ, ямар зохион байгуулалт байх вэ гэдгийг бид нар заавал ярих ёстой. Жишээ нь энэ би түрүүн хэлсэн түүх, соёлын музейн дурсгалт зүйл 24 сая төгрөг үнэлэгдээд байж болохгүй. Үндэсний телевизийн энэ том хөрөнгө, энэ том байр 16 тэрбумаар үнэлэгдээд байж болохгүй. Энгийнээр ярих юм бол одоо 5 давхар байшин ч 16 тэрбумаар зарагдахгүй. Энэ бол зах зээлийн бодитой. Тэгэхээр үнэлгээгээ дахиад хийлгэх хэрэгтэй. Энэ эхнийх нь.

Хоёрдугаарх нь түрүүн тэр сэтгэл ханамжийн судалгааг заавал хийлгэх хэрэгтэй. Энэ та нарын ажлын үзүүлэлт байхгүй юу. Тэгэхдээ энийг хараат бусаар хийлгэхгүй бол хараат компани руу хийлгэж болохгүй. Тэгээд яг ний нуугүй хэлэхэд Үндэсний телевиз 2024 оныхоо тайлангаа Үндэсний зөвлөлөөр оруулаагүй юм байна гэдэг асуудлыг энд ярьж байна. Тэгэхээр 2025 оны тайланг бас оруулаагүй байгаа гэсэн үг. Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хорооны Их Хуралд яагаад танилцуулахаар хуульчилсан юм бэ гэхээр уг нь үйл ажиллагааг чинь ил тод тайлагнадаг хэлбэр рүү л оруулах гээд байгаа шүү дээ. Өөрөө өөртөө тайлагнадаг биш, томилогддог, төсвийг чинь баталж өгдөг, Улсын Их Хурал дтайлагнадаг болгох гээд байгаа. Энийг олон нийт мэдээсэй гэж л оруулж байгаа юм.

Тэгээд бас дахиад яг ний нуугүй хэлэхэд үндэсний телевизийн асуудал дээр манайхан маш их болгоомжтой ханддаг юм. Манай ялангуяа улс төрчид. Муулахаар гаргадаггүй байхгүй юу. Мууг нь ярьчихаар гаргадаггүй үндэсний телевизээр. Хар тамга дарчихдаг. Үгүй ээ яг жинхэнээсээ. Сайдлаад магтаад байхаар гаргаад байдаг юм. Энэ чинь нөгөө улс төрийн хараат байдал байхгүй юу. Тэрнээс утасдаад л тэрийг гарга, энийг гарга гэхгүй л байх л даа. Томилсон субъектээс нь. Яг бодитоор ингэж хар тамга дардаг байхгүй юу. Зарим нь бүүр бүх үүд хаалга нь нээлттэй. Магтсан нь гаргадаг, магтаагүй нь гаргадаггүй.

Хувийн телевизүүд өнөөдөр нийт эфирийнхээ 30-35 хувь, зарим нь 40 хувийг ямар нэгэн байдлаар худалдаж контент спонсор, эсвэл худалдаж хөрөнгө олдог, мөнгө олдог. Тэгэхээр түрүүн Ганбаатар гишүүний хэлж байгаатай адилхан 2 хувийг 8 хувь болгоход бид нар хэчнээн төгрөгийн санхүүгийн боломж үүсэх юм бэ гэдгийг тооцож үзэх хэрэгтэй. 2 хувиар миний ойлгосноор 5 орчим тэрбум төгрөг олж байгаа юм байна гэж ойлгосон. Зөв үү тайлан дээрээс? 8 хувь болохоор хэд юм? Заавал сэтгэлд ханамжгүй байгаа хүнээс 1000 төгрөг авах шаардлага байхгүй юм чинь зүгээр зах зээлийн багтаамж харуулж байна шүү дээ. 5 хувь болгоход орлого чинь 8 тэрбум болох нь байна шүү дээ. 8 хувь болгоход 10 хэдэн тэрбум болох нь байна. Зар сурталчилгааны орлого.

Тэгэхээр ийм тооцооллоо заавал хийж үзвэл яасан юм бэ гэсэн нэг ийм юм байгаа. Тэгээд яг энэ Үндэсний телевиз буцаж энэ одоо хөрөнгийнхөө үнэлгээг сайжруулахгүй бол зүгээр яг зүгээр муухайгаар хэлье объектыг нь хувьчлачихвал яах юм, ийм лобби орж ирвэл яах юм? Тэгээд 16 тэрбумаар үнэлэгдээд энэ том объект чинь зарагдах нь байна шүү дээ.

Тэгэхээр энэ үнэлгээнүүдээ би та бүхнийг эргэж хараад заавал хийлгээсэй гэх гээд байгаа юм. Одоо энэ чинь хийдэг бас төрийн байгууллагууд байгаад байна шүү дээ.

Хоёрдугаарт түрүүн асуулт авах гээд амжаагүй юм. Байр ашиглалтын яг зарцуулалт нь хэдэн хувь байдаг юм, 100 хувь гэж үзэх юм бол 80 хувь нь үр ашигтай зарцуулагдах, 20 хувь нь үр ашиггүй зарцуулдаг тоо байгаа шүү дээ. Тэрэнтэй адилхан хэрвээ тийм байвал тэр контент үйлдвэрлэлээ одоо төв болговол яасан юм гээд түрүүн бас Ганбаатар гишүүн хэлж байсан уу. Ийм саналуудыг та хэд маань яагаарай. Энэ хуульд бараг өөрчлөлт орж таарах л юм шиг байна миний ойлгосноор.

Тэгэхээр тэр дээр Үндэсний телевизийнхэн саналуудаа сайн өгөөрэй. Тэгээд хоорондоо хурлаа хийгээд эхлээд тайлангаа танилцуулаад шууд ингээд Их Хурал руу ороод ирэхээр та нарын хувьд ч ойлгомжгүй, бид нарын хувьд ч ийм юу хэлэлцээд байгаа нь утга учиргүй болчихож байгаа байхгүй юу бүтэн 2 жилийн дараа. Тэрийг л хэлэх гэсэн юм.

Ц.Сандаг-Очир: Алтангэрэл гишүүн саналаа хэлье.

О.Алтангэрэл: Сая манай Онон гавьяат хэлж байна шүү дээ ирц бүрэлдсэн тэгээд энэ хурал цуглаан хийгээгүй шүү гээд. Би бол одоо энэ Онон гишүүнийг худлаа ярьсан гэж бодохгүй байна. Үгүй ээ нэг ийм зөвлөлөөрөө учраа олоод хурлаа хийчхээд дараа нь Их Хурал дээр асуудлаа хэлэлцүүлдэг баймаар байна. Наадах чинь бас арай дэндүү шүү дээ. Бүүр Их Хурлаар дамжиж төрийн институцүүдийн саналаар томилогддог байж байж хуулийнхаа дагуу гүйцэтгэх үүргээ ч хийчихгүй. Түрүүчийн хурал дээр чинь бараг буруутгах маягийн юм болоод байна шүү дээ. Ирүүлчихсэн тайланг удаалаа энэ тэр гээд. Их Хурал дээр бид нарын буруугаас боллоо энэ тэр. Тэгсэн чинь бүүр зөвлөлөөрөө ч хэлэлцээгүй болж таарлаа шүү дээ. Энэ яаж байгаа юм бэ? Өөр газрын жишээлбэл компанийн ч юм уу, энэ ТУЗ энэ тэр хуралдаад, ашгийн төлөө байгууллага ийм юм болсон бол аль хэзээний дампуурчихсан байгаа шүү дээ. Харин хаа очиж энэ үндсэн ажил бол харин гайгүй явж байгаа юм байна.

Би түрүүн тэр асуулт дээр Хөх тэнгэр радиог онцолдог нь энэ. Дэлхий даяар энэ Монголын радиог сонсдог зөндөө хүн байдаг юм. Одоо бид нар ганцхан телевиз ярьдаг болчихсон. Монголын радио гэдэг үнэхээр энэ өв соёл агуулсан арвин баялаг түүхтэй бид нар орхиж болшгүй энэ хөгжлийнхөө гадуур нь орхиж болшгүй ийм газар байгаа юм шүү. Үгүй ээ тэгээд ер нь бид телевизийн хураамжтай холбоотой, санхүүжилттэй холбоотой зөндөө асуудлаа л ярьдаг. Ер нь хүн DDish-ийнхээ картыг сунгаж чадахгүй болоод, Юнивишн-ийхээ мөнгийг төлж чадахгүй болоод зурагтаа асаавал ганцхан манай үндэсний телевиз л гардаг юм шүү дээ. Тэнд зарцуулах мөнгөгүй, тэрийгээ төлж чадахгүй үндэсний телевизээ үзээд сууж байгаа зөндөө байгаа. Тэгээд одоо жишээлбэл манай Үндэсний телевиз дээр сүүлийн үед одоо би үзэгч хүний хувьд хэлэхэд зөндөө олон ахиц

дэвшил гарч байна лээ л дээ. Одоо энэ залуучуудын сонирхдог тэр чиглэлийн зүйлүүд, тэгээд шинээр энэ өв соёлтой холбоотой юмандаа шинээр хийгээд зөндөө олон ахиц дэвшил гарч байна лээ.

Тэгэхээр зөвлөн зөвлөл шиг байгаад дэмжээд энэ одоо гайгүй явж байгаа үйл ажиллагаагаа сайн дэмжээд өгөөч. Үйл ажиллагааныхаа энэ дэс дараалал, энэ тайлангаа хэлэлцүүлэх, үйл ажиллагаагаа удирдах, чиглэлээ өгөх, тэр Хяналтын зөвлөлийнхөө үгийг сонсох гээд энэ юмнуудаа хуулийн дагуу олигтойхон шиг хийгээд өгөөч. Тэгээд энэ Улсын Их Хурал дээр авчраад Улсын Их Хурлын бүтцийн байгууллага дээр авчраад тайлан ч байхгүй хооронд уг яриа нь зөрдөг ийм байдалтай баймгүй байна.

Ер нь дараа нь манай Төрийн байгуулалтын байнгын хорооныхон Сандаг-Очир дарга аэнэ асуудлуудыг нь бас харж баймаар юм байна. Дотроо ярьсан юм уу, хэлэлцүүлсэн юм уу, одоо энэ байдлаараа жишиг тогтчихоод л бид нар энд тэгээд л тэр зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулаад л баахан юм яриад л, томилоод л, тэр институцүүд нь санаа зовоод л ингээд байж ер нь яах вэ дээ. Энэ чинь ерөөсөө 1 ийм контент бэлддэг газар төдий биш, энэ Монгол үндэстний оюун санаа санааны дархлаанд маш чухал үүрэгтэй ийм том институцийн асуудал.

Сайн яривал энэ ардчилалтай холбоотой үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой нэгэн институцтэй холбоотой асуудал гэж бид нар бас харж, хандаж байхад та бүхэн маань өөрсдөө дараагийн удаад гишүүд нь дотроосоо бас санаачилга гаргаад, дарга нь бас манлайллаа үзүүлээд ийм дутуу тайлантай, ийм олон асуудалтай, тэгээд дотроо ийм эв нэгдэлгүй ийм баймааргүй байна. Ядаж энэ үндэсний эв нэгдэл өв соёлыг уламжлагч энэ байгууллагын удирдлага нь дотроо эв нэгдлээ олохгүй болохоор яаж энэ доошоогоо юм чинь олигтой явах юм бэ гэдэг ийм л логик харагдаж байгааг цаашдын үйл ажиллагаандаа анхаараасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Хэрлэн гишүүн гараад явсан. Зулпхар гишүүн саналаа хэлье.

С.Зулпхар Бид тайлангаа анх удаа сонслоо. Анх удаа сонсохдоо бас нарийн мэдээллүүд ч гэсэн авч байна. Сайн юм. Яг ийм л тайлан цаашдаа бас хэлэлцэгдэж байх байх жил болгон. Гэхдээ жил болгон яг ийм байдлаар хэлэлцэгдэхгүй байх гэж бодож байна. Юу гэхлээр зэрэг угаасаа зөвлөлийн гишүүд маань, Үндэсний зөвлөлийн гишүүд маань өөрсдөө хүсэл сонирхлоо илэрхийлж байж энэ зөвлөлийн гишүүд бус уу ийм хүмүүс гэж ойлгож байгаа. Тэгэхээр зэрэг ийм учраас сая одоо гишүүдийн хэлсэнчлэн үндэсний хэмжээний ийм зөвлөлүүдэд байгаа гишүүд маань өөрсдөө энэ хамтын манлайлал гэж зүйлээ хэрэгжүүлмээр байна. Манлайлал та бүхэн хэрэгжүүлэхгүй бол Их Хурал дээр ирээд тайлан тавихаар зэрэг бид нар та бүхэнд ингэж манлайлаарай гэдэг юм заагаад сууж байдаг энэ нь өөрөө утгагүй гэсэн үг. Салбарын хувьд хамгийн асуудлыг сайн мэддэг чиглэл чиглэлийн улсууд та нар учраас өөрсдөө ингэж оролцох байх гэсэн бодолтой байна.

Хоёрдугаарт, нэгэнтээ одоо үйлчилж байгаа хуулийн хүрээнд хийж болох ажлуудаа та хэд хийгээч ээ гэж байгаа юм. Энэ орон тооны бус зөвлөл гээд ингээд чухал байгаад байна шүү дээ. Орон тооны бус зөвлөлийн чинь 8.50 дээр ингэчихсэн байгаа юм. Орон тооны бус зөвлөлийг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл байгуулж болох бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүнд

сэтгүүл зүй, улс төр, эрх зүй, хэрэглэгчдийн эрх ашиг, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, урлаг, шашин, байгаль орчин, спорт зэрэг чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг оруулна гэхчхэн байгаа юм.

Тэгэхлээр энэ одоо телевизийн өөрийнх нь одоо мэргэшсэн түвшинд энэ бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд гол дэмжлэг үзүүлэх бас бүтэц энд байна гэсэн үг. Хуулиар олгогдсон боломжийг та бүхэн ашиглаач ээ гэж байгаа юм. Бусад үндэсний хэмжээний зөвлөлүүд дээр энийг хуульд өөрчлөлт оруулаад байгуулж үзсэн үр дүн гарч байна. Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл дээр дэргэд нь одоо 1 зөвлөл, 1 хороо байгуулсан юм. Тэр мэргэжлийн хороо байгуулсан. Тэгээд Хяналтын зөвлөл байгуулсан. Мэргэжлийн хороо нь үндсэндээ тэр Нийгмийн даатгалын сангийн менежментийг ямар нэгэн жишээ нь субъектээс хамааралгүйгээр хэрэгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө өгдөг энэ үр дүн эхнээсээ гарч байгаа юм. Яг энэнтэй адилхан энийг уг нь 20 жилийн өмнө бодоод олчихсон зүйлийг 20 жил бид нар хийгээгүй явж байгаа бол одоо хий гэж байгаа юм. Энэ бол менежмент нь шүү гэж байгаа юм. Хуулийн хувьд боломж нь бага бол та бүхэн ажиллаач ээ гэж байгаа юм.

Гурав дахь зүйл. Өнгөрсөн хугацаанд мэдээж хэрэг бас сайн зүйлүүд гарсан байх. Тэрнээс гадна одоо бид нар гаднын улсуудын туршлагыг яриад сууж байна. Энэнтэй уялдуулсан байдлаар та бүхэн Үндэсний зөвлөл ямар бодлого барих юм, ямар одоо шинэчлэл хийх юм, ямар одоо жишээ нь тодорхой зохион байгуулалтыг бид нар өөрчлөх юм гээд энэ шийдвэрээ бас гаргаад яв. Тэрийгээ бидэнтэй бас хэлэлцээд танилцуул гэж.

Сая санхүүжилтийн хэлбэртэй холбоотой тодорхой юм ярьж байна шүү дээ. Санхүүжилтийг бол гишүүд юу гэж ярьж байна гэхээр зэрэг тэр хураамж гэдэг нэлээн хоцорсон зүйл байж магадгүй. Хэрвээ хоцорсон зүйл юм бол энийг одоо шинэ хэлбэрээр яах юм, төрөөс татаас өгөх юм уу, өгөх юм бол яаж өгөх юм. Тэрнээс гадна та бүхэн тэр нөгөө маркетингийнхаа бодлогыг яах юм, тэр нь гэхдээ бас хязгаартай байх байлгүй хуулиар. Энэ дээр та бүхэн шийдвэр гаргуулах дээр бас ажиллаач.

Санхүүжилтийн схем дээр чинь хүртэл одоо асуудал байна шүү дээ сая ярьж байгаа дээр. Сангийн сайдын одоо багц дотор та бүхний одоо жишээ нь төсөв тэнд байж байна. Гэтэл уг нь Их Хурлаа жишээ нь Үндэсний зөвлөл нь сонгож томилогддог ийм байгууллага атлаа яагаад Их Хурлын томилогддог байгууллагыг Сангийн яаман дээр байж байгаа юм, Сангийн сайд дээр байж байгаа юм. Энийг хүртэл ярих ёстой.

Цаашлаад жишээ нь та бүхэн тэр хүний тоо ярьж байна. Хүний тоо байнга ярина. Тэр хүний нөөц чинь үнэхээрийн хангалттай юм уу, эс үгүй бол илүү юм уу, болж байгаа юм уу, болохгүй байгаа юм уу? Үүнтэй холбоотой яах юм, жишээ нь цалин мөнгөний асуудал ярих юм уу? Сайн цалинтай биш бол энэ телевиз дээр чинь сайн хүн дээр чинь сайн хүн тогтохгүй шүү дээ. Ойлгомжтой шүү дээ. Жишээ нь би энд Номин сайд сууж байна. Номин сайд телевизийн чиглэлээр сайн мэргэшсэн хүн энд эфирт нь ажилладаг жишээ нь мэдээ уншдаг хүнийг л авчрахдаа их өндөр цалинтай л жишээ нь урьж авчирсан байдаг юм билээ. Тэгэхээр энэ чинь цаанаа өөрөөр хэлбэл бүх юм одоо бодлогоороо байх ёстой бол цалин дээр хүртэл та бүхэн бас бодлогоо гаргаж хийгээч ээ гэж байгаа юм. Ингэж байж бид нар телевизийг байгаа түвшинд.../минут дуусав./

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Бас өөрийнхөө хувьд бас саналаа хэлье.

МҮОНРТ гэж байгаа. Бусад арилжааны телевизүүдээс ялгагдах юм нь та бол, та бүхэн бол Монголын Үндэсний олон нийтийн эрх ашгийг хамгаалсан тэдний дуу хоолой болж ажиллах ёстой үндсэн чиг үүрэгтэй. Төрөөс дэмжлэг, санхүүгийн дэмжлэг авч явж байгаа ийм ялгаатай олон нийтийн радио, телевиз. Тэрнээс энэ радио, телевиз бол дарга нарын телевиз биш. Энэ радио, телевиз бол Засгийн газрын гэдэг юм уу, Их Хурлын телевиз биш. Үзэгч, сонсогчид юу хүсэж байна тэрний илэрхийлэл болж байх ёстой. Тэр үүднээсээ олон нийтийн гэдэг энэ тодотголоо энэ тал дээрээ, байх тал дээрээ ажиллах нь бодлогыг барьж ажиллах нь радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гэж хэлж болох энэ та бүхний 15 гишүүдийн үндсэн чиг үүрэг энэ. Тэрнээс хэн нэг сонгогдсон субъектийнхээ гэдэг юм уу энэ талаас асуудалд хандаж ерөөсөө болохгүй шүү гэдгийг нэгд хэлэх ёстой.

Тэгээд та бүхний одоо хариулж байгаа хариултуудаас эд нар бас энэ байдал алдагдчих гээд байдаг юм уу, буруу зөрүү ойлголцсон гэдэг юм уу, цаашлаад улс төржөөд явдаг асуудал, хандлагууд байдаг, байгааг одоо үгүйсгэхгүй, үгүйсгэхийн аргагүй байна. Тийм учраас одоо бас энэ асуудлуудыг.

Нөгөө талаар Их Хурал ч бид нар бас буруутай юм байна. Энэ одоо субъектүүдийг сонгож явуулж байгаа. Ингээд сонгож явуулсан нөхдүүд маань бас яг энэ чиг үүргээрээ ажиллахгүй, хурал чуулгандаа суудаггүй, төсөв төлөвлөгөөг нь баталдаггүй, үйл ажиллагааг нь хянадаггүй, ярьдаггүй, Хяналтын зөвлөхийн тайланг сонсдоггүй ийм байдлаар явдаг алдаа, дутагдлууд байна.

Тийм учраас одоо энэ тайлан хэлцэлж сонссоны дараа бид нар бас томилгооны бүрэн эрхийн хугацаа нь дуусаж байгаа гишүүдийг бас томилгооны сонсголууд хийх ажил, асуудлууд хүлээгдэж байгаа. Энэ дээр ч гэсэн одоо Их Хуралд өөрөөсөө сонгогддог субъектүүддээ анхаарах ёстой юм байна. Тэгээд тэнд олон нийтийн эрх ашгийг хангаж ажиллана гэж сонгогдчихоод очоод ажлаа хийдэггүй ингээд явж болохгүй шүү дээ. Тэгээд яг тэр мэргэжлийнхээ чиг үүргээр асуудалд хандаж байна уу, үгүй юү.

Хамгийн гол нь нэвтрүүлгийн бодлого шүү дээ. Хөтөлбөрийн бодлого шүү дээ. Өнөөдөр Үндэсний олон нийтийн радио, телевиз энэ өдрийн 24 цагийн эфирийг яаж зөв зохистой ашиглаж байна вэ? Та бүхний тэр нэвтрүүлгүүдийн тэр хүүхдийн сэтгэл зүй, олон нийтийн соёл, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа чинь энд хэр хангагдаж байна вэ гээд яривал олон асуудлууд байгаа байх аа. Энэ бас дэлхий нийтэд Монгол Улсыг сурталчлах толь шүү дээ нөгөө талаас.

Тийм учраас та бүхэн хамгийн оюунлаг, хамгийн чадварлаг боловсон хүчин. Одоо авдаг цалин мөнгө нь хариугүй бага л юм байна шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Гар дээрээ сая 100, 200 төгрөг аваад сууж байдаг уран бүтээлчид л гэж ярьж байна.

Гэхдээ миний авсан мэдээллээр Үндэсний зөвлөлийн гишүүд харьцангуй өндөр урамшуулал авдаг гэж мэдээлэл авсан шүү. Тэгсэн хэр нь ажлаа хийхгүй байгаа юм. Өнөөдөр бид нар энд Үндэсний зөвлөлийн тайланг л сонсох үүрэгтэй. Гэрэл захирлын товч үйл ажиллагааны мэдээллийг сонссон. Гэрэл захирал бол Монсор даргад ажлаа тайлагнах үүрэгтэй. Ингээд Үндэсний зөвлөл дотроо энэ Их Хурлаар, Төрийн байгуулалтын байнгын хороогоор оруулж ирж тайлагнах

тайлангаа уг нь дотроо хэлэлцээд за болж байна яг энэ тайланг танилцуулъя гээд ингээд батлуулаад ороод ирээд хэлэлцээд явах ёстой юм байгаа шүү дээ Монсор даргаа.

Тэгтэл та бас түрүү 7 хоногт бид нар ахиад хойшлуулсан ингээд энэ энэ 7 хоногт ярьж байна. Яах вэ одоо анхны юм, анх удаа Төрийн байгуулалтын байнгын хорооны ингэж тайлан хэлэлцэж байгаа гэж ингэж үзье. Одоо бид нар энэ 25 оны тайланг эрт хэлэлцэнэ. Та бүхэн тайлан юмаа эртхэн ирүүлээрэй. Дотроо батлагдсан тайлан юмнуудаа авчраарай. Хэлэлцсэн тайлангаа оруулж ирээрэй. Ингээд 25 оны 1 дүгээр улиралд багтааж аль болох энэ үйл ажиллагааны чинь Үндэсний зөвлөлийн тайланг хэлэлцэхийг бодъё 26 оны. Тэгэхгүй бол бид нар бас одоо цаг хугацааны хувьд оройтсон, хойшлогдсон юмнууд бий.

Нөгөө талаар сая та бүхэн тэр хураамж 24 онд саналаа өгсөн Засгийн газар ямар шалтаг, шалтгаанаар өнөөдрийг хүртэл энэ асуудлыг хэлэлцэхгүй байгаа юм гэдэг асуудал байгаа юм байна.

Нөгөө талаар 20 жил болж байгаа өнөөдрийн энэ хуулийн зарим зүйл, зохицуулалтууд бас одоо орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй сайжруулах зүйл, заалтууд байгаа юм байна гэж ойлголоо. Би сая асуултдаа та бүхнээс хуулийн төсөл боловсрогдож байгаа хэрэгцээ шаардлагатай ийм боловсруулсан зүйл байна уу гэхээр ерөөсөө хариулт авч чадсангүй.

Тэгэхээр ер нь цаашдаа бас одоо энэ хуулийн үзэл санаа, зүйл, заалтыг сайжруулах чиглэлээр ажлын хэсэг гаргах хэрэгцээ шаардлага байгаа юм байна. Зарим одоо гишүүд сая хэлж байна. Ганбаатар гишүүн эд нар бүүр хяналтын сонсгол хийх хэрэгцээ шаардлага байна гэж байна. Хяналтын тухай хуулиар одоо бас хяналтын сонсгол хийх эрх зүйн нөхцөл байна. Би бүүр хуулийн заалтыг нь уншиж өгье. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д Улсын Их Хурал хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх, Үндэсний олон нийтийн радио, телевизийн хуулийн хэрэгжилтийг дүгнэнэ ээ гэсэн үг. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг явуулна. 29.2.2 дээрээ Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд ингээд заавал одоо хяналтын сонсголыг хийгээд явах ийм бололцоо байна.

Тэгээд манай Байнгын хорооны гишүүд ийм саналуудыг гаргаж байгаа учраас энийг цаашдаа бас Байнгын хороон дээрээ яриад хяналтын сонсгол юмыг зохион байгуулах тэр бололцоо боломж нь хуулиар нээлттэй байгаа учраас ярилцаж байгаад энийг одоо хэлэлцэх асуудлыг цаашдаа ахиад нягтлаад хэлэлцэнэ.

Нөгөө талаар хууль тогтоомжийг сайжруулах санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг бас гаргана. Танай байгууллагаас Удирдах зөвлөлийн гишүүдээс чинь дэд ажлын хэсэг гаргаж яг одоо та бүхнийг үйл ажиллагаа амьдрал дээр үйл ажиллагаа явуулахад аль хуулийн аль зүйл, заалт нь зөрчилдөөд байгаа юм. Амьдралтай нийцэхгүй байгаа юм, үйл ажиллагаатай нийцэхгүй байгаа юм. Чөдөр тушаа болж байгаа зүйл нь юу байгаа юм. Буруутай, зөрүүтэй зүйл нь юу байгаа юм гэдгийг хэдүүлээ ярилцаж та бүхний санал хүсэлтэд тулгуурлаж хуулийн сайжруулах, боловсруулах ажлын хэсгийг гаргаж хамтарч ажиллая.

Мөн 24 онд Засгийн газарт өгсөн тэр санал, хүсэлтийг чинь бид нар бас одоо цаашид хөөцөлдөж, үнэ тариф нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага, сардаа 1000 төгрөг үү? 600-1100 юм уу? 600 төгрөгөөс 1100 төгрөгийн л тариф авч байгаа юм байна гэж ойлголоо. Тийм үү айл өрхөөс, хэрэглэгчдээс сардаа. Энэ төсөв юмаар цаашдаа ямар бололцоо, боломж байгаа юм, нэмэгдүүлэх үнэ тариф нөгөөдүүл Засгийн газрын хэмжээний асуудал байх тийм ээ. Энэ асуудлыг бас Засгийн газар тойрох асуудлыг ярьж байна. Төсвийн энэ хуваарь, төсвийн одоо багц байна. Сангийн яамны сайдын, Сангийн сайдын багцад яваад байх нь хэр зохимжтой байгаа юм, энэ нь өөрөө танай үйл ажиллагаанд хараат бус байх байдалд яаж нөлөөлж байгаа юм гэдэг энэ асуудал одоо хөндөгдөж байна гэх мэт мэтчилэн олон асуудлуудыг манай гишүүд, сая Номин гишүүн маш чухал асуудлуудыг яриад байна лээ шүү дээ. Үзэгчдийн тэр контентын чинь эрэлт хэрэгцээ, судалгаа юмнууд ямар байгаа юм гээд манай Зулпхар гишүүн энэ тэр гээд асуугаад байгаа зүйлүүд олон байна. Танай төсвийн бүтцийг харахаар маш боломжгүй ер нь их хүнд бүтэц байна шүү дээ. Төсвийн бүтэц чинь. Одоо 25 тэрбум төгрөгийн төсөвтэй та бүхэн. Энэ 600 хэдэн хүн 25 тэрбумаар амьдарч байгаа тийм ээ. Үүний чинь үндсэндээ Засгийн газраас 10 тэрбумыг нь өгчхөж байна шүү дээ шууд татаасаар.

Тэгээд та бүхэн 15 цаана нь 15 тэрбум төгрөгийг өөрсдөө олж байна гэсэн үг олж байна гэсэн үг. Өмнө нь 5 тэрбумыг өгдөг байсан. Засгийн газар харин дэмжлэг үзүүлэх, татаас өгөх юман дээр аягүй сайн ажиллаж энэ үүргээ сайн биелүүлсэн юм байна. 2 дахин нэмэгдүүлж 10 тэрбум болгосон. Энэний хүчинд өнөөдөр та бүхэн өр, авлагаа барагдуулаад, цалин мөнгөө цаг хугацаанд нь тавиад ингээд өр ширгүй явж байгаа юм байна гэж би ойлголоо. Тэгээд энэ мөнгө багасчихвал яах юм бэ гэдэг асуудал. Дандаа Засгийн газар энэ хэмжээний тэтгэмж, татаас өгч чадах уу, үгүй юү гэдэг асуудал гэх мэтчилэн ингээд.

Тийм учраас одоо та бүхэн орлогоо нэмэгдүүлэх бололцоо ,боломж юу байгаа юм, контент үйлдвэрлэл дээрээ анхаарах юмнууд нь юу байгаа юм гээд. Энэ барилга объектууд чинь хуучнаараа үнэлгээтэй явж байна. Одоо өнөөдрийг хүртэл одоо ингэж явна ч гэж юу байх вэ дээ. Тэр том барилга өнөөдөр 15 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байна гэж Шижир гишүүний асуугаад байгаа асуулт юу байх вэ дээ. Энэ одоо барилга байгууламж, объектуудаа, үнэлгээгээ шинэчилж сайжруулаач ээ. Ингээд Үндэсний зөвлөлийн хийх асуудлууд, ажлууд зөндөө л байгаа юм байна. Хяналтын зөвлөл чинь одоо Үндэсний зөвлөлийнхөө гишүүнд ороод явдаг, дарга нь Үндэсний зөвлөлийн гишүүн байгаад явдаг энэ бүтэц чинь хэр зохимжтой юм. Энэ чинь өөрөө өөрөө өөрийгөө хянах гээд байгаа юм уу хаашаа юм гэдэг асуудал яригдаж байна. Энэ бүтэц чинь хэр зохимжтой байгаа гэдгээ Үндэсний зөвлөлийн дарга бас наад бүрэлдэхүүн дээрээ яриач ээ. Үндэсний зөвлөлийн 15 гишүүнээ нийт ажилчдынхаа орон тоонд оруулаад батлаад явдаг асуудал байж хэзээ ч болохгүй. Энийгээ засаж залруулаач ээ гээд яриад байвал Үндэсний зөвлөлийн одоо хийж хэрэгжүүлэх, шийдвэр гаргах энэ ажлууд чинь одоо зөндөө байгаа юм байна гэж өнөөдрийн энэ одоо тайлан, мэдээллийн хурлаас харагдаж байна. Тэгээд юуны өмнө анх удаа байсан буруу зөрүү бүрхэг тодорхойгүй юмнууд байсан байх. Гэхдээ одоо хэдүүлээ цаашдаа 25 оныхоо төсөв, төлөвлөгөө, тайлангаа улам илүү чамбайруулаад илүү сайн тайлантай орж ирээрэй гэж хүсэж байна. Энэ саяын яригдсан асуудлуудыг цаашдаа засаж залруулах чиглэлээр Төрийн байгуулалтын байнгын хорооны өөрийнхөө эрхлэх асуудлын хүрээнд ажлын хэсэг гаргах зүйл дээр нь ажлын хэсэг гаргаад, хяналтын одоо сонсгол хийх юман дээр нь энэ асуудлыг одоо хууль дүрмийн дагуу зохион

байгуулаад, Засгийн газарт зарим чиглэлээр үүрэг чиглэл өгч, өгөх юм нь энэ дээр нь анхаараад ингээд явъя гэж ингэж бодож байна.

Ингээд өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хороогоор Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны 24 оны тайланг хэлэлцэж дууслаа.

Та бүхэндээ одоо бас баярлалаа. Ажлын амжилт хүсье.

Ингээд гурав дахь асуудал. Шижир гишүүн танилцуулна тээ. Санал хураахгүй ээ.

12.51 цаг

Гурав дахь асуулт асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир танилцуулна. Шижир гишүүний микрофоныг өгье.

Ө.Шижир: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны товч тайлан болон боловсруулсан санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Аубакир, Баярбаатар, Батбаяр Ганбаатар, Б.Заяабал, Ө.Шижир, Д.Энхтүвшин нар ажиллалаа.

Ажлын хэсэг нийт 5 удаа хуралдаж, 1 албан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнд захиалга өгч төрийн хяналт шалгалтын харьцуулсан судалгаа, хүнс, эм, барилга, уул уурхай, цөмийн энергийн салбар судалгааг хийлгэлээ.

Ажлын хэсэг 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа яам, агентлагуудын төлөөллүүдийг оролцуулсан өргөн хүрээний хэлэлцүүлгийг өрнүүлж, тэдгээрийн илтгэл, мэдээллийг сонссон.

Мөн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Хяналт шалгалт үнэлгээний үндэсний хороо Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын төлөөллүүдтэй албан уулзалт хийж, төрийн хяналт шалгалтын тогтолцооны шинэчлэлийг цаашид хэрхэн төгөлдөршүүлэх талаар мөн санал солилцсон.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн хяналт шалгалтын хууль нь 2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдан мөрдөгдөж байна. 4 бүлэг, 16 зүйлтэй тус хуульд нийтдээ 13 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн

нэмэлт, өөрчлөлт, мөн Улсын Их Хурлын 2022 оны 72, Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 417 дугаар тогтоол, “Мэргэжлийн хяналтын чиг үүргийн салбарыг яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 469 дүгээр тогтоолуудаар Мэргэжлийн хяналтын газрыг татан буулгаж, төрийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг салбарын яамд шилжүүлсэн.

Ингэснээр 11 яам, агентлаг салбарын хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. 2023 оноос өмнө төлөвлөлт, төлөвлөгөөт бус гүйцэтгэлийн шалгалтуудыг урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа, хяналт шинжилгээ, шалгалт, баталгаажуулалт, үйл ажиллагаа, зөвлөн туслах үйлчилгээ гэсэн арга хэрэгслээр хэрэгжүүлж байсан бол 2023 оноос хойш салбарын хяналтад шилжсэнээр шалгах, урьдчилан сэргийлэх гэсэн арга хэр хэрэгслээр хэрэгжүүлж байна.

Өөрөөр хэлбэл, зөвлөх, соён гэгээрүүлэх ажил нь орхигдсон. Ажлын хэсэг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн мэдээлэлд дурдсанаар 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын 34 нь Улаанбаатар хотод, 66 хувь нь аймгуудад хийгдсэн. 2024 онд хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд 45.5 мянган зөрчлийг илрүүлж, 40.1 хувь, 18.2 мянган зөрчлийг арилгасан.

Арилгасан зөрчлийг байгууллагаар авч үзвэл Стандарт, хэмжил зүйн газар 89 хувь, Эрчим хүчний яам 81.6 хувь, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар 72.2 хувь, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам 68.5, Зам, тээврийн яам 65.3 хувьтай зөрчлийг арилгасан байна. Эрүүл мэндийн яам 31.7, Боловсролын яам 45.1, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам 48 хувь, төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг хамгийн бага арилгасан гэжээ.

Мөн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын өргөдөл, гомдлоор хийсэн байна. 2024 оны 10 дугаар сарын байдлаар хийсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг байгуулахаар авч үзвэл Хүнс, хөдөө аж ахуйн салбарын яам 3375 ширхэг буюу 50.2 хувь, Эрүүл мэндийн яам 1712 ширхэг буюу 25.5 хувь, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн.

2024 оны 10 дугаар сарын байдлаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг байгууллагаар авч үзвэл Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яам 2044 буюу 40.3 хувь, Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яам 823 буюу 16.2 хувь, Стандарт, хэлжил зүйн газар 11.5, Гэр бүл, хөдөлмөр, хамгааллын яам 11 хувь зэрэг урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн байна.

2024 оны 10 дугаар сарын байдлаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зорилгоор 21.5 мянган зөрчлийг илрүүлж, 61.9 хувь буюу 13.3 мянган зөрчлийг арилгасан. Харин 2023 онд 55.7 мянган зөрчлийг илрүүлсэн бөгөөд 56 хувь буюу 31.2 мянган зөрчлийг арилгасан байна.

Салбарын хяналтын тогтолцоонд шилжсэнээс хойш Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас явуулсан судалгаанд хамрагдсан 4 байгууллага тутмын 1 нь 26.4 хувь нь хяналт шалгалтын улмаас тухайн байгууллагад ямар нэгэн хүндрэл бэрхшээл учирсан гэж хариулсан. Хүндрэл, бэрхшээл учирсан аж ахуйн нэгж байгууллагуудын дийлэнх нь хяналт шалгалтын бичиг баримтын давхардал, түүний дотор хяналтын хуудас, хугацаа, давхардаж ирэх, хяналтын процесс удаан,

зөвлөн туслах зорилгогүй торгох, том, жижиг байгууллагад тавигдах стандартуудтай холбоотой хүндрэлүүдийг дурдсан байна.

Дүгнэлт Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, төрийн аудитын байгууллага болон хуульд заасан эрх бүхий байгууллагын хяналт шалгалт, Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын хяналт, нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлж хяналт шалгалтаас бүрдэнэ ээ гэж, 3.2 дахь хэсэгт Улсын Их Хурал, Ерөнхийлөгч хяналт шалгалт, Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын хяналт болон төрийн аудитын байгууллагатай холбогдсон харилцааг тус тусын хуулиар зохицуулна гэж тус тус зааснаас үзвэл төрийн байгууллага, албан тушаалтнаас явуулах хяналт шалгалтыг төрийн хяналт шалгалтад хамааруулахаар өргөн хүрээнд хуульчилсан бөгөөд тус тусын хуулиар зохицуулснаас үлдсэн харилцаа нь буюу салбарын хяналтын үйл ажиллагаа нь хуучнаар мэргэжлийн хяналтынх үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулж байна.

Захиргааны хяналт буюу мэргэжлийн хяналтын гол онцлог нь хууль тогтоомжийн биелэлтэд мэргэшсэн байгууллагаас тавих хяналтын үйл ажиллагаа бөгөөд хөндлөнгийн хараат бус байх, хосолмол байх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгахын тулд албадлага хэрэглэх эрхтэй байх зэрэг гол шинжийг агуулна.

Гэтэл салбарын хяналтын үйл ажиллагаанд дараах асуудал тулгарч байна. Үүнд:

1.Хяналт шалгалтын нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалт хяналтгүй байна. Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан Хяналт шалгалт хийх нийтлэг журмын 1.6-д хяналт шалгалтын 1 объектод хэд хэдэн хяналт шалгалтын байгууллага хяналт шалгалт хийх бол эдгээр байгууллагыг хяналт шалгалтыг хамтран төлүүлж зохион байгуулах журмыг баримтална гэсэн заалт хэрэгжихгүй байна.

2.Хяналт шалгалтын мэдээллийн шилэн хяналтын нэгдсэн систем ажиллахгүй байна. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1.2-т заасан хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх ажил хэрэгжилт хангалтгүй, шилэн хяналтын нэгдсэн систем шинэчлэгдээгүй, цахим систем нь ажиллахгүй байгаа нь хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн санг бүрдэхгүй хяналт шалгалтын статистик тоон мэдээлэл гарахгүй гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх боломжгүй нөхцөл үүссэн байна. Хяналт шалгалтын хэлбэр шалгах, торгох руу илүү чиглэсэн зөвлөх, туслах, соён гэгээрэл үйлчилгээнд байхгүй болсон.

Аж ахуйн нэгж байгууллагууд төрийн хяналт шалгалтаас хамааран хүндрэл бэрхшээл нэмэгдсэн. Судалгаанд хамрагдсан 4 байгууллагууд тутмын нэг нь хяналт шалгалтын улмаас тухайн байгууллагад ямар нэг хүндрэл бэрхшээл учирсан гэж харуулсан. Учирсан хүндрэлийг авч үзвэл хяналт шалгалтын бичиг баримтын давхардал 2-3 газраас сард давхардаж ирэх, хяналтын процесс нь удаан гэх мэт хүндрэлүүдийг дурдсан. Тодорхой тохиолдлыг дурдвал Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газарт 2023 онд 9 яам, 1 агентлагийн 36-гийн хяналт очсон бол 2024 оны 10 дугаар сарын байдлаар 8 яам, 1 агентлагийн 33 удаагийн хяналт шалгалт очсон байна. “Шинь шинь” ХХК-д 2023 онд 6 яам, 1 агентлаг 13 удаагийн хяналт шалгалт очсон бол 2027 онд 10 сарын байдлаар 2024 оны 10 дугаар сарын байдлаар 6 яам, 1 агентлагийн 16 удаагийн хяналт шалгалт

очсон байна. “Жол” ХХК-д 2023 онд 3 яамны 12 удаагийн хяналт шалгалт очсон бол 2024 оны 10 дугаар сарын тухайн байдлаар 3 яамны 10 удаагийн хяналт шалгалт очсон байна.

5.Салбарын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлж буй яам агентлагуудын мөрдөж байгаа хууль тогтоомжийн жагсаалтыг нэгтгэн авч үзвэл 2025 оны байдлаар хүчин төгөлдөр мөрдөж буй 336 зүйл, 1146 заалт бүхий 103 хууль байна.

Төрийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулахад нийт 72 хуульд өөрчлөлт оруулах саналыг Засгийн газрын холбогдох байгууллагаас гаргасан. Учир нь хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил их байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 7, 1.2 дахь хэсэгт зааснаар Байгалийн ургамлын тухай хууль зөрчихөд улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч арга хэмжээ авахаар зөрчил шалган шийдвэрлэх буюу тухайн хуулийн 1.8-ын зүйлийн 6.27-д заасан боловч салбарын хууль буюу Байгалийн ургамлын тухай хуульд үндсэн зохицуулалт нь байхгүй.

Өнөөдөр салбарын хяналт шалгалтыг явуулахад улсын байцаагч нь тухайн салбарын хууль тогтоомжоос гадна Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг шууд хэрэглэх болж байгаа нь хууль хэрэглээний талаас төвөгтэй байдлыг үүсгэж байна.

Салбарын хууль тогтоомжийг давхардуулж бууруулах, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулахаар 11 яам, 4 агентлагаас ирүүлсэн санал тогтоомжид өөрчлөлт оруу оруулахаар 11 яам, 4 ангиллаас ирүүлсэн саналыг агуулгаар нь авч үзвэл зөрчилдөж байгаа хуулийн заалт 34, чиг үүргийн давхардал 26, хийдэл 43, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 76 заалт байна.

Нийтлэг байдлаар хууль тогтоомжийн болон төрийн захиргааны чиг үүргийн давхардал, хийдэл, зөрчил их байна.

6.Хяналтын чиг үүрэг хэрэгжүүлж буй нэгж, албан тушаалтнуудаас дараах саналыг гаргасан. Үүнд:

Салбарын хяналт яамандаа очсоноор хөндлөнгийн хяналтыг хийхээс илүү яамны дотоод хяналт, үнэлгээний ажлыг хийж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахгүй байна.

Зөвшөөрлийн тухай хуулиар тусгай зөвшөөрөл олгодог газарт хөндлөнгийн хяналтад очсоноор 1 хаалганд зөвшөөрөл өгөөд нөгөө хаалгаар хянах асуудал бий болж бүрэн утгаараа хэрэгжихгүй байна.

Аюулгүй байдалтай холбоотой хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхээс илүүтэй төлбөр тооцоо, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг хэлэлцэж, шалгадаг хяналт үнэлгээ, дэмжлэгт хяналт гэсэн нэрээр хяналт хийж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулахгүй хяналт байдлыг их хийж байна.

7.Гадаадын зарим улс орнуудын харьцуулсан судалгаанаас дүгнэхэд улс төр өөрийн түүхэн нөхцөл байдал, эдийн засгийн бүтэц, геополитикийн нөхцөл байдлаас хамаарсан төрийн хяналт шалгалтын тухай өвөрмөц тогтолцоотой байна.

Гэхдээ олон улсын стандарт, хэм хэмжээ, бүс нутгийн интеграцын үйл явцтай эрх зүйн орчин, хяналтын тогтолцоогоо уялдуулан хөгжүүлж байна. Тогтолцооны түвшин улс орон бүрд харилцан адилгүй байна. Эстони, Японд харьцангуй төвлөрсөн. Нэгдсэн удирдлагад Казахстан, Гүрж, Узбекистанд хяналтын чиг үүрэг нь хэд хэдэн яам, агентлагт хувиарласан байна.

Эдгээр улсууд сүүлийн жилүүдэд хяналт шалгалтын давхарлаг арилгахад шинэчлэлийн бодлогоо чиглүүлж байна. Нийт судлагдсан улсуудын хувьд эрсдэлд суурилсан хяналтын арга хэмжээг аргачлалыг нэвтрүүлэхийг зорьж байна. Ажлын хэсгээс манай улсад сүүлийн үед тулгамдаж байгаа яаралтайгаар шийдэл хайж байгаа хүнс, эм, барилга, уул уурхай, цөмийн энергийн салбарын хяналтыг Гүрж, Казахстан, Узбекистан, Эстони, Японы жишээн дээр судлан үзлээ. Хүнсний салбарт Эстони улс Европын холбооны нэгдсэн тогтолцоотой уялдсан, төвлөрсөн системтэй. Япон, Казахстан олон шатлал тогтолцоотой байв. Гүйцэт төвлөрсөн бус тогтолцоотой Узбекистан олон улсын жишигт нийцүүлэх шинэчлэлийг хийж байна.

Эмийн салбарт.

Эмийн салбарын хяналтад олон улсын байгууллагууд, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бүс нутгийн хамтын ажиллагаа, Европын холбоо гэх мэт голлох нөлөө үзүүлсэн байна. Япон, Эстони улс орон улсын стандартад нийцсэн төвлөрсөн хяналтын тогтолцоотой бол Казахстан, Гүрж, Узбекистан улсуудад олон улсын жишигт нийцүүлэх ажил явагдаж байна. Улс орнууд эмийн чанар, аюулгүй байдалд үр нөлөөг хангах зорилгоор сайн туршлага, олон улсын стандартыг нэвтрүүлж байна.

Барилгын салбарт.

Барилгын салбарын хяналт нь аюулгүй байдал, чанарын стандарт, байгаль орчны нөлөөлөл зэрэгт төвлөрдөг. Улс орнуудын хяналтын тогтолцоо харилцан адилгүй. Япон, Эстони төвлөрсөн, нарийвчилсан зохицуулалттай байхад Казахстан, Гүрж, Узбекистанд хяналтын чиг үүрэг нь ОУБ-д хуваарилагдсан шинэчлэлийн шатад байна. Олон улсын ISO стандарт Европт голлох нөлөө үзүүлдэг.

Уул уурхайн салбарт тус салбарын хяналт нь байгаль орчны хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, нөөц ашиглалт, татвар хураамж зэрэг өргөн хүрээг хамаардаг. Япон? Эстони харьцангуй тогтворжсон байгаль орчинд ээлтэй зохицуулалттай бол Казахстан, Гүрж, Узбекистан зэрэг байгалийн нөөцөд суурилсан эдийн засагтай улсууд хяналтын тогтолцоог боловсронгуй болгох олон улсын сайн туршлага нэвтрүүлэх шаардлагатай.

Цөмийн энергийн салбарт.

Энэ салбарын хяналт нь аюулгүй ажиллагаа, цацрагийн хамгаалалт, цөмийн хяналт, материалын хяналт, хаягдлын менежмент зэрэгт онцгой анхаарал хандуулдаг бөгөөд олон улсын атомын энергийн газрын стандарт, удирдамж, заавар голлох үүрэгтэй.

Судалгаанд хамрагдсан улсуудаас Япон, Казахстан, Узбекистанд цөмийн энерги ашигладаг, эсвэл түүхий эдийг олборлодог тул олон улсын атомын энергийн газартай нягт хамтран ажилладаг. Аюулгүй байдлын соёлыг бэхжүүлэхэд анхаардаг Эстони, Гүрж улсууд нь цөмийн энерги ашигладаггүй ч цацрагийн эх үүсвэрийн хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Санал сүүлийн хуудас, нүүр. Хууль тогтоомж, бүтэц тогтолцооны давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, үүний тулд шинэ үзэл баримтлалыг гаргаж ирэх, шинэчлэлийн үйл ажиллагаанд зөвхөн салбарын албан хаагчаас гадна энэ талын мэргэшсэн судлаач, эрдэмтэд мэргэжлийн сургалт, судалгааны байгууллагуудыг татан оролцуулах.

2.Хууль тогтоомжийн шинэчлэх хүрээнд төрийн хяналт шалгалтын бүх байгууллагуудын хувьд өнөөг хүртэл маргаантай нэгдсэн ойлголтод хүрээгүй байгаа нэр томъёог цэгцлэх.

Тухайлбал, хяналт шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалт, мониторинг, аудит, үнэлгээ, мөрдөн шалгах үйл ажиллагаа гэх мэт нэр томъёо ухагдахууныг нэг мөр ойлгож хэрэглэх, хэвшүүлэх. Нэр томъёог тодорхой болгосноор үйл ажиллагаагаа тус бүрийн арга хэрэгсэл, зорилго, зориулалт, хамрах хүрээ, объект, субъект нь тодорхой болно.

3.Ажлын хэсэг нь тодорхой хууль тогтоомжийн төсөл боловсруулаагүй болно. Учир нь ажлын хэсэг салбарын оролцоотой хэлэлцүүлгийн үр дүн болон судалгааны материалууд, хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдалтай танилцахад төрийн хяналт шалгалтыг боловсронгуй болгох 72 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар байна.

Монгол Улсад төрийн хяналт шалгалтыг явуулах үндсэн үзэл баримтлал нь тогтоогүй, нэгдсэн ойлголтод хүрээгүй байгаа тохиолдолд Улсын Их Хурлаас ийм тооны хуулийн төслийг дангаар санаачлан боловсруулах боломжгүй юм. Мөн салбарууд өөр өөрсдийн чиглэлээр асуудлыг харж дүгнэж байгаа өнөөгийн нөхцөлд хууль тогтоомжийн уялдаатай холбоотойгоос гадна тус тусын хуулиар төрийн хяналтыг явуулдаг бусад бүтцийн байгууллагын чиг үүрэгтэй хэрхэн уялдах талаар сайтар бодож боловсруулах шаардлагатай.

4.Ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт, саналтыг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлж, асуудлыг шийдвэрлэх боломжийг нөхцөл нь суллаж, хамтран ажиллах замаар үүсээд буй хүндрэлтэй нөхцөл байдал тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. Ажлын хэсгийн ахлагч Д.Энхтүвшин, ажлын хэсгийн гишүүд Норовын Алтанхуяг, Т.Аубакир, Б.Баярбаатар, Д.Батбаяр, С.Ганбаатар, Б.Заяабал, Ө.Шижир. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Шижир гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу?

Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Алтангэрэл гишүүн асуулт, үг цуг шүү. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Би үг хэлнэ. Харьцангуй бас богино хугацаанд их сайн ажилласан байна гэж харж байгаа юм. Энэ төрийн хяналт шалгалтын асуудал ерөөсөө асар чухал асуудал шүү дээ. Ер нь хяналт гэдэг эрх мэдлийг эдэлдэггүй

эрх мэдэл гэдэг үг байдаг. Эрх мэдлийн балансыг хамгийн сайн тэнцвэржүүлдэг өөрөө бүхэл бүтэн цогц системтэй асуудал. Харамсалтай нь ингээд энэ төрийн хяналт шалгалт маш чухал асуудал ярьж байхад дарга нар маань ч байдаггүй, сайд нар маань ч байхгүй ингээд анзаарч байгаа хүн байхгүй л байна л даа энд. Гишүүд маань ч ер нь алга.

Тэгэхээр энэ дүгнэлт дээр энэ дурдагдаад байгаа хамгийн чухал асуудал энэ бол хяналт, шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалт, мониторинг, аудит, үнэлгээ, мөрдөн шалгах үйл ажиллагаа гэх мэт нэр томьёо ухагдахууныг нэг мөр ойлгож хэвшүүлэх, хэрэглэх гэдэг энэ маш чухал ойлголт яваад байгаа юм. Одоо яам, тамгын газрын бүтэц нь хүртэл тийм байгаа шүү дээ. Хяналт шинжилгээ, үнэлгээ мониторингийн газар, Хяналт шинжилгээ, аудитын газар гэдэг ч юм уу ингээд өөр өөр нэр томьёотой явдаг. Өөрсдөө энийгээ ойлгодоггүй ийм байгаад байгаа юм.

Дээрээс нь энэ төрийн хяналт шалгалтын тогтолцоо гэж их том тогтолцоог сууриар нь ерөөсөө хардаггүй. Төрийн хяналтын дээд байгууллага бол аудитын байгууллага. Тэгээд аудитын байгууллага жил болгон дүгнэлт гаргадаг хэдэн их наядаар нь зөрчил ярьдаг, яриад өнгөрдөг, энэ аудитаас хэрэгжүүлсэн арга хэмжээний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө юм нь байдаггүй, цогцоороо боловсруулагддаггүй. Энэ бол Монгол төрийн бидний сул байгаагийн хамгийн том шалтгааны нэг нь болчхоод байгаа юм. Хэн нэгэнд хариуцлага тооцдоггүй, хяналт шалгалтын механизм нь үр дүнтэй ажилладаггүй.

Тэгэхлээр харин зүгээр энэ санал дээр ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт, саналыг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлж, асуудлыг шийдвэрлэх боломж нөхцөлийг судалж, хамтран ажиллах замаар үүсээд буй хүндрэлтэй нөхцөл байдалд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна гэсэн дээр энэ ажлын хэсгийн ахлагч, ажлын хэсэгт багтсан гишүүд ер нь энэ олон хяналт шинжилгээтэй холбоотой хяналттай холбоотой энэ олон хуультай хуулиудыг нэгтгээд бие даасан хуулийн төсөл боловсруулах энэ чиглэл рүүгээ та бүхэн маань бас ажиллахыг бодож үзээсэй. Энэ тийм хурдан хийгдэхгүй л дээ.

Тэгэхдээ бид энэ хяналтынхаа асуудлыг сайжруулчихвал төрд нүүрлээд байгаа олон асуудлууд, тэр дундаа энэ авлигын асуудал шийдэгдэх урьдач том нөхцөл нь болно шүү. Энэ бол зөвхөн өнөөдөр ийм хэдхэн гишүүний хооронд ярилцаад манай Байнгын хороон дээр санал, дүгнэлт сонсоод өнгөрөх асуудал биш та бүхэн маань ажлаа гүйцээж, энэ хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаас гадна тусдаа бие даасан томоохон хуулийн төсөл боловсруулах чиглэл рүү та бүхэн минь бас ажиллаасай гэж ингэж хүсэж байна. Тэгээд ажлын хэсэгтээ баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Би бас яг Алтангэрэл гишүүнтэй санал нэг байна. Энэ дүгнэлтийн 6 дахь хэсэгт их том том дүгнэлтүүд байгаа юм. Тэгээд танай энэ бас ажлын хэсэгт орсон гишүүд бас нэлээн богино хугацаанд гэхэд би бас чамгүй сайн боломжийн ажиллачихсан юм болов уу гэж байгаа юм. Энэ 6 дээр 3 том дүгнэлт байгаа юм. Салбарын хяналт яамандаа очсоноор хөндлөнгийн хяналтыг хийхээс илүү яамны дотоод хяналт, үнэлгээний ажлыг хийж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахгүй байна гэж нэг дэх дүгнэлт. Их чухал.

Хоёр дахь бүүр чухал. Зөвшөөрлийн тухай хуулиар тусгай зөвшөөрөл олгодог газарт хөндлөнгийн хяналт нь очсоноор нэг хаалганд зөвшөөрлөө өгөөд нөгөө хаалгаар хянах асуудал бий болж бүрэн утгаараа бас хэрэгжихгүй байна.

Гурав дахь нь мөн адилхан. Аюулгүй байдалтай холбоотой хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхээс илүүтэйгээр зүгээр төлбөр тооцоо, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг шалгадаг, хяналт үнэлгээ, дэмжлэгт хяналт гэсэн нэрээр хяналт хийж, Төрийн хяналт шалгатийн тухай хуулиар зохицуулаагүй хяналт шалгалтыг их хийж байна гэсэн ийм. Би энэ 6 дугаартай энэ дүгнэлтийн энэ 3 дүгнэлт их чухал эдний ажлын хэсгийн гаргаж ирсэн гол дүгнэлтүүд энд яваад байгаа юм байна даа гэж харж байгаа. Тэгээд үнэхээр одоо бас энэ Хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурал бид нарыг ард түмэн юу гэж шүүмжил хэлээд байна вэ гэхээр хууль үйлдвэрлээд батлаад байдаг. Баталсан хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэж ингэж шүүмжлээд байгаа шүү дээ.

Тэгэхээр бид нар одоо ингээд яг ингээд энэ ажлыг нь дүгнээд, тайлагнаад гараад ирэхээр алдаа, зөрчил нь хаанаа байна гээд ингээд ярихаар бас л одоо гишүүд, Байнгын хороод, Засгийн газраас ингээд л хяналт, оролцоо хангалтгүй байна, ач холбогдол өгөхгүй байна ийм байна.

Тийм учраас одоо ажлын хэсэгт би бас Алтангэрэл гишүүнтэй санал нэг. Ингээд дүгнээд гаргаад ирээд зогсохгүй яг энэний одоо үр дүнг гаргаж, цаашдаа аль хуульд ямар хуулийг сайжруулах хэрэгцээ, шаардлага байгаа юм гэдэг юман дээрээ хэдүүлээ анхаарч, энэ ажлыг нэг мөр дуусгахгүй бол зүгээр хяналт шалгалт хийчихлээ, алдааг нь гаргаад ирчихлээ, санал, дүгнэлт боловсруулчихлаа гээд ингээд дутуу орхиж болохгүй. Нэгмөсөн гүйцээгээд энийг дагасан мөрөөр ямар хууль, эрх зүйн орчны хяналт шалгалтыг улам сайжруулах юм гэдэг ийм асуудлыг нэг цогцоор нь авч үзэж байж энэ ажил үр дүнд хүрэх юм байна гэж ингэж бодлоо.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонслоо.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Чуулган, хуралдаа идэвхтэй оролцож суусан нийт гишүүддээ баярлалаа. Алтангэрэл гишүүн, Номин гишүүн, Ариунзаяа гишүүн, Зулпхар гишүүн, Шижир гишүүн. Мөн хуралдаа, ирцдээ орсон гишүүдэд бас талархал илэрхийлье. Баярлалаа.

13.12 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

